




# СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.04.09 №14 (10691)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

## Цаг үе-Үйл явдал

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд өргөн барьсан билээ.

Монгол Улсын Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэг, түүнийг хэрэглэх онол, арга зүйд гарч буй сүүлийн үеийн өөрчлөлтийг хэрэгжүүлж, мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг бие бүрэлдэхүүнийг бий болгох, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэхээр төслийг боловсруулсан байна. Энэ талаар холбогдох албан тушаалтнуудаас тодрууллаа.

## ЗЭВСЭГТ ХҮЧИНД БАРИЛГА-ИНЖЕНЕР, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ШААРДЛАГА, НӨХЦӨЛ БҮРДСЭН

Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Г.САЙХАНБАЯР



**Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болсон үндэслэл, хэрэгцээ, шаардлагын талаар Та мэдээлэл өгнө үү?**

Зэвсэгт хүчний тухай хуулиар Зэвсэгт хүчин нь Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг гэсэн хоёр төрлийн цэргээс бүрддэг. Өргөн барьсан хуулийн төсөлд Зэвсэгт хүчний бүтэцэд шинэ төрлийн цэрэг болох Барилга-инженерийн цэргийг байгуулах, түүнээс гадна кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэгжийг бий болгох эрх зүйн зохицуулалтыг тусгаад байна. Сүүлийн жилүүдэд төмөр зам, авто зам, барилга байгууламж, газрын тосны үйлдвэрийн дэд бүтэц зэрэг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг Зэвсэгт хүчний анги, байгууллага, цэргийн алба хаагчид гүйцэтгэсэн. Тухайлбал, Монголын газрын тос боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн хүнд даацын авто замын төсөл болон "Халх гол" сумын шинэчлэлийн ажлуудыг хэрэгжүүлж дуусгалаа. Мөн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг угсрах, доод бүтцийг барих ажлыг хийж байна.

Дээр дурдсан ажлын үзүүлэлт, үр дүнгээр улс орны стратегийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг мэргэжлийн чадварлаг бие бүрэлдэхүүнтэй, орчин үеийн өндөр хүчин чадал бүхий техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан, зохион байгуулалттай хүч хэрэгслээр хийж гүйцэтгэх нь өндөр үр дүнтэй болохыг төр, засгийн удирдлага анхааран үзэж, Зэвсэгт хүчний бүтэцэд ийм чиглэлийн төрлийн цэрэг байгуулах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн.

Төрлийн цэрэг гэж хуулиар тогтоосон чиг үүргийг бие дааж, эсхүл бусад төрлийн цэрэгтэй хамтран гүйцэтгэх зориулалт бүхий Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн хэсэг хэмээн хуульчлан тодорхойлсон

байдаг. Эдгээр байдлыг бодолцон барилга-инженерийн цэргийг байгуулах эрх зүйн зохицуулалтыг нь хийх юм. Энэхүү хууль гарснаар Зэвсэгт хүчнийг чадваржуулах, цэргийн алба хаагчдад мэргэжил эзэмшүүлэх, залуучууд цэргийн алба хаах хугацаандаа эх орныхоо бүтээн байгуулалтад өөрийн хувь нэмрээ оруулах, тодорхой мөнгөн хуримтлалтай болох зэрэг ач холбогдолтой.

Дэлхийн улс орнуудын Зэвсэгт хүчинд тайван цагт улс орныхоо бүтээн байгуулалтад оролцдог барилгын, барилга-инженерийн, төмөр замын, зам-гүүрийн гэх мэт төрлийн цэрэгтэй байх нийтлэг жишиг байдаг.

Барилга-инженерийн цэргийн үндэс суурийг тавих ажил 2010 оноос эхэлж, Засгийн газрын шийдвэрээр Зэвсэгт хүчний бүтэцэд ангиудыг байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлээд байна. Мөн ЗХЖШ-ын бүтэцэд Бүтээн байгуулалтын ажил хариуцсан газар байгуулж ажиллаад эхэлсэн. Түүний боломж, чадавхыг нэмэгдүүлэх, үүрэг, хариуцлагыг нь тодорхой болгох үүднээс төрлийн цэрэг болгож байгаа юм.

**Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэрэг бүтээн байгуулалтад оролцохоос гадна ямар чиг үүрэгтэй байх талаар тодруулна уу?**

Барилга-инженерийн цэрэг нь зөвхөн улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох үүрэгтэй гэж ойлговол өрөөсгөл юм. Энэхүү төрлийн цэргийн хүлээх үүргийн талаар дэлгэрэнгүй ярья.

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах үндсэн үүрэгтэй. Энэхүү үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бэлтгэлийг тайван цагт хангадаг. Энэ хүрээнд болзошгүй түрэмгийллийг няцаахад улс орныг бэлтгэх гэсэн томоохон арга хэмжээг Зэвсэгт хүчин хэрэгжүүлдэг. Ялангуяа өргөн уудам газар нутагтай манай улсын хувьд тайван цагт нутаг дэвсгэрээ бэлтгэх, оперативын төхөөрөмжлөлийн ажлыг хийж гүйцэтгэх үүрэг нь барилга-инженерийн цэргийн үндсэн үүрэг байх юм.

(Үргэлжлэл нь II нүүрт)

## ТӨЛӨВЛӨЛТИЙН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛЖ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮНГ НЭМЭГДҮҮЛЭХЭД АНХААРЧ АЖИЛЛАНА

БХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, хурандаа Д.ГАНХУЯГ

үнэлгээ хийх журам", "Батлан хамгаалахын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын

**БХЯ-ны ХШҮДАГ-аас 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлуудын талаар мэдээлэл өгнө үү?**

-Юуны өмнө Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Монгол Улсын яамдын 2018 оны үйл ажиллагаанд өнгөрсөн онд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр Батлан хамгаалах яам төрийн бусад яамдыг тэргүүлсэн нь манай яамны төдийгүй Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нийт бүрэлдэхүүний хичээл зүтгэлийн үр дүн, үйл ажиллагааны нэг чухал үзүүлэлт гэдгийг дурдах нь зүйтэй. Бодлогын баримт бичгүүдэд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилт, яамны 2019 оны үйл ажиллагаагааг дүгнүүлэхээр тайлан, холбогдох материалуудаа зохих журмын дагуу энэ жил хүргүүлээд байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2019 онд дэвшүүлсэн "Батлан хамгаалах салбарын хяналт, шалгалтын үр нөлөө бүхий тогтолцоог бэхжүүлэх, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд бодлогын үнэлгээ хийх, Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх, төсөв, санхүүгийн эрсдэлийг үнэлэх, хараат бус дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт явуулах, зөрчил, дутагдлыг таслан



зогсоох, урьдчилан сэргийлэх, хэрэглэгчдийг үнэн зөв, бодит мэдээллээр хангах" зорилго, зорилтуудаа бүрэн хангаж, удирдлагыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангах үүргээ биелүүлсэн.

**Гол арга хэмжээнүүдээсээ тоймлон дурдана уу?**

-Хяналт, шалгалтын тогтолцоог бэхжүүлэх, шаардлагатай дүрэм, журмыг боловсруулан батлуулах зорилтын хүрээнд "Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", "Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,

журам", "Зэвсэгт хүчний хэмжил зүйн дүрэм"-ийг шинээр болон шинэчлэн боловсруулж, Батлан хамгаалахын сайдын тушаалаар баталгаажуулснаар сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт болон төрийн өмчит байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу үр нөлөө бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийхэд мөрдөх удирдлага, зохион байгуулалтын асуудлууд шийдвэрлэгдэж, эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болно.

(Үргэлжлэл нь II нүүрт)

## ЗЕНИТЧДЭД ЗОРИУЛСАН ДУРСГАЛЫН ЦОГЦОЛБОР УДАХГҮЙ СҮНДЭРЛЭНЭ

Цэргийг довтолгооноос хамгаалах агаарын эсэргүүцэн цэрэг үүсэн байгуулагдсаны 83 жил, "Зенитчдийн холбоо"

командлалын Цэргийг агаарын довтолгооноос хамгаалахын дарга, хурандаа Б.Эрдэнэпил, Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн захирагч, хурандаа

бүрэлдэхүүн цэргийн тангараг давтаж, тэдний дунд шатар, теннис, гүйлтийн тэмцээнийг зохион байгуулж шилдгүүдээ тодрууллаа. Энэ үеэр Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч,



Төрийн бус байгууллага байгуулагдсаны 10 жилийн ойн баярын өдрүүдийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн байрлалд үе үеийн зенитчдэд зориулсан "Дурсгалын цогцолбор хөшөө"-г байгуулахаар боллоо. Тус хөшөөний шавыг тавих ёслол энэ сарын 6-ны өдөр зохион байгуулагдсан бөгөөд энэхүү арга хэмжээнд Зэвсэгт хүчний ХЗЦ-ийн

С.Батболд, "Зенитийн холбоо" ТББ-ын тэргүүн, чөлөөнд байгаа хошууч М.Ягаан нар оролцлоо. Уг цогцолборыг нэг сарын хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд үе үеийн зенитчдийн алдар гавьяаг мөнхөлж, Цэргийг агаараас хамгаалах жагсаалд хүчин зүтгэж байгаа хойч үедээ өвлүүлэн үлдээх дурсгал болж байгаа аж. Мөн тус арга хэмжээний хүрээнд ангийн бие

бригадын генерал Б.Амгаланбаатар мэндчилгээ илгээсэн бөгөөд мэндчилгээндээ "Хуурай замын цэргийг агаарын довтолгооноос хамгаалах их үйлсэд эрдэм бүтээл, хөдөлмөрөө зориулсан эрхэм генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчид, ажилтан алба хаагчид, ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж байгаа зенитчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа дайчид та бүхэндээ Цэргийг агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах цэрэг үүсэн байгуулагдсаны 83 жилийн ойн мэндийг өргөн дэвшүүлбэ. Бидний хамтдаа бүтээсэн амжилт бүхэн халуунд халж, хүйтэнд хөрг зүтгэсэн ахмад үеийнхэн, тэдний үйл хэргийг залгамжлан, эх орондоо тангараг өргөн зүтгэж, ирээдүй өөд тэмүүлсэн зенитчдийн маань хичээл зүтгэлийн үр дүн байдгийг дурдах ёстой. Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн Цэргийг агаарын довтолгооноос хамгаалах ариун жагсаалд орж, алтан шаргал нар, мөнх хөх тэнгэрийг сахин хамгаалах ашдын хүндтэй үүргийг хүлээсэн эрхэм зенитчдэдээ албанд нь амжилтын дээдийг хүсэн өрөө. Эх орны тэнгэр цэлмэг, эрхэм зенитчдийн сум нь мэргэн байг" гэжээ.

# ЗЭВСЭГТ ХҮЧИНД БАРИЛГА-ИНЖЕНЕР, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ШААРДЛАГА, НӨХЦӨЛ БҮРДСЭН

(Түрүүч нь I нүүрт)

Үүнээс гадна улсын онц чухал объект, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарын барилга, инженерийн байгууламжийг барих, сэргээн засварлах, дайны болон гамшигын дараах сэргээн босгох ажилд оролцох, хүмүүнлэгийн тусламж, энхийг дэмжих ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох зэрэг өргөн цар хүрээтэй үүргийг хүлээх юм.

**Хуульд орсон бас нэг асуудал нь кибер аюулгүй байдлыг хангах, түүнийг хэрэгжүүлэх нэгжийг Монгол Улсын Зэвсэгт хүчинд байгуулах талаар та дээр дурдсан. Энэхүү асуудлыг хуульд тусгах ямар хэрэгцээ, шаардлага байгаа вэ?**

-Нэгдүгээрт, Дэлхийн кибер орон зайн аюулгүй байдал үндсэндээ алдагдаж, улс орнуудын аюулгүй байдалд шууд утгаараа заналхийлж байна. Дэлхий дахинд үйлдэгдсэн кибер халдлагын улмаас жилд дунджаар хоёр их наяд ам.долларын эдийн засгийн хохирол учирч байна.

Халдлагыг нягтлан шинжилж үзвэл 80 орчим хувь нь гэмт хэргийн, эдийн засгийн сэдэлтэй байхад үлдсэн 20 орчим хувь нь улс төрийн зорилготой үйлдэгдэж байна.

Дэлхийн улс орнууд олон хэмжээст ертөнцийн тав дахь орон зай болсон кибер орон зайг хамгаалах хүчнийг Зэвсэгт хүчиндээ байгуулж, асар их төсөв, хөрөнгө зарцуулж байна. Би зөвхөн ойрын хоёр жишээг дурдъя. 2019 онд АНУ 15 тэрбум, БНХАУ 7,3 тэрбум ам.долларын хөрөнгийг кибер цэрэгтээ зарцуулаад байна. Манай улс шиг жижиг орнууд кибер цэргийг байгуулах, бүрдүүлэх чиглэлд том гүрнүүдээс дутахгүй анхаарч байна. Жишээлбэл, Эстони 1,3 сая хүн амтай жижиг улс хэдий ч НАТО-ийн кибер аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий бие даасан кибер командлалтай, 300 орчим кибер цэрэгтэй улс болоод байгаа нь томоохон Зэвсэгт хүчинтэй улсуудыг ч энэ чиглэлээр ардаа орхиод байна. Афганистан, Бангладеш, Танзани хүртэл кибер цэрэгтэй 67 улсын жагсаалтад багтжээ. Иймд орчин үеийн техник, технологийн хөгжилд суурилсан "шинэ" дэлхий ертөнцөд аюулгүй оршин тогтнох үндэс суурийг бэхжүүлэх, кибер орон зайн аюулгүй байдлыг хангах хэрэгцээ, шаардлага өдөр тутам, маш хурдацтайгаар тавигдаж байна.

Хоёрдугаарт, манай улс мэдээлэл, харилцаа холбооны хэрэглээгээрээ өндөр боловч кибер орон зайгаа хамгаалах тал дээр олон арван жилээр хоцорч байна. Монгол Улсад бүртгэгдэж байгаа кибер халдлагыг нэгтгэсэн

гаднын байгууллагын статистик дүн мэдээг харахад дэлхийн дунджаас даруй найм дахин их байна. Бид өөрсдөө энэ тоог нэгтгэж гаргах чадамжгүй. Товчоор хэлэхэд, манай улсад кибер орон зайг хамгаалах төрийн тогтолцоо үгүйлэгдэж байна. Тэр тусмаа Батлан хамгаалах салбарт.

Улс орны кибер орон зайн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт иргэд, хувь хүн, төрийн болон хууль, хүчний байгууллагууд шат шатандаа өөр өөрсдийн үндсэн чиг үүргийн хүрээнд оролцох боломжоор хангагдсан байхаар энэ тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай юм.

Монгол Улсын кибер орон зайг батлан хамгаалах төрийн тогтолцоог "Кибер аюулгүй байдлын тухай" анхдагч хуулийг баталж мөрдөх, "Зэвсэгт хүчний тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар бүрдүүлэх боломжтой. Ийм учраас Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар кибер аюулгүй байдлыг хангах нэгжийг Зэвсэгт хүчний бүтцэд байгуулах, улс орон, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний кибер орон зайн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, кибер батлан хамгаалах тогтолцооны цаашдын хөгжлийг хангах нь чухал ач холбогдолтой юм.

## МОНГОЛ УЛСЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ ДЭЛХИЙГЭЭС 20-25 ЖИЛЭЭР ХОЦРОГДСОН

ЗХЖШ-ын дэргэдэх Зэвсэгт хүчний кибер аюулгүй байдлын төвийн дарга, дэд хурандаа С.ШИРБАЗАР

**УИХ-д өргөн баригдаад буй Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгааныг та товч танилцуулахгүй юу?**

-Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах замаар Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд улс орны кибер орон зайг батлан хамгаалах кибер цэргийг байгуулах асуудал яригдаж байна. Өнөөдөр дэлхий нийтийн кибер орон зайд кибер халдлагын тоо, төрөл, хор хохирлын хэмжээ нэмэгдсэн, дэлхийн улсууд кибер зэвсгээр эрчимтэй хөөцөлдсөн байдалтай байгаа нь энэхүү орон зайд аюулгүй байдал алдагдсан гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Монгол Улс кибер аюулгүй байдлаа хамгаалж чаддаггүй цөөхөн улс орны нэг болчихсон байна.

НҮБ-д бүртгэлтэй 195 орчим орноос 67 улс кибер цэрэгтэй болж, кибер хил хязгаараа хамгаалж байхад манай улсад дорвитой алхам хийгдэлгүй удлаа. Энэ салбарт бид дэлхийн улсуудаас 20-25 жилээр хоцорчихсон явж байгаа. Бидэнд нэн шаардлагатай байгаа зүйл бол улс орны кибер орон зайг хамгаалах төрийн тогтолцоог бүрдүүлэх ажил юм. Үүнийг хоёр хуулиар зохицуулах боломжтой. Нэг нь кибер аюулгүй байдлын тухай анхдагч хууль. Ийм хуулийн төсөл боловсруулагдан Засгийн газар дээр элэлцэгдээд явж байна. Нөгөөх нь Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар Зэвсэгт хүчинд кибер хүчинтэй болох. Ийм хоёр асуудлыг шийдвэл бид улс орны хэмжээнд тогтолцоогоо бүрдүүлж авах боломжтой юм. Энэ ч шаардлагаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан.

**Та аял манай улсын кибер аюулгүй байдал 20-**



**25 жилээр хоцрогдсон гэж хэллээ. Өнөөгийн байдлыг тодорхойлол...**

-Олон улсын байгууллагаас кибер аюулгүй байдлын индексээр нь жагсаахад манай улс дэлхийн 195 орноос 127-д бичигдэж байна. Үүнийг тодруулбал, манайх кибер аюулгүй байдлаас хамгаалах төрийн тогтолцоо болоод менежмент байхгүй, кибер цэргийн ажиллагаа хийх чадамжгүй гэж тооцогдож байна. Гэмт хэрэгтэй тэмцэх гэсэн үзүүлэлтээр дөрвөн оноо авсан нь манай цагдаагийн байгууллагын ажлын үзүүлэлтийг харуулж байна. Тэгэхээр манай улсын кибер орон зайн аюулгүй байдал хангалтгүй гэсэн үг. Хэр тааруухан байгаагаа нэгтгэж харах техникийн нөхцөл одоохондоо манайд дутмаг байна. Бид тодорхой ажлуудыг эхлээд явж байгаа. Монгол Улсын Зэвсэгт хүчний бүтцэд Зэвсэгт хүчний кибер аюулгүй байдлыг хамгаалах үндсэн чиг үүрэг бүхий Зэвсэгт хүчний "Кибер аюулгүй байдлын төв" 2019 онд Монгол Улсын

Засгийн газрын тогтоолоор байгуулагдан үйл ажиллагаагаа эхлээд байна. Одоо хэрэгжиж буй төслүүд энэ эрчээ алдалгүй амжилттай хэрэгжвэл бид ойрын ирээдүйд Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдлыг нэгтгэж харах чадамжтай м э р г э ж и л т э й боловсон хүчин, тоног төхөөрөмжөөр хангагдах боломж бүрдэнэ. Энэхүү бүрэлдэж буй чадамжийг улс орны кибер орон зайг хамгаалахад бүрэн ашиглах хууль, эрх зүйн орчинг яаралтай бүрдүүлэх шаардлагатай байгаа юм.

**Х у у л ь хэрэгжиж, техник, тоног төхөөрөмжөөр хангагдчихлаа гэхэд мэргэжлийн, чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх талаар хэрхэн анхаарч байна вэ?**

-Хүний нөөцийн асуудал дээр бид гаднын хөгжилтэй орнуудтай хамтран таван жилийн хугацаатай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Тодруулбал, кибер аюулгүй байдлын боловсон хүчнийг өндөр хөгжилтэй орнуудад нарийн мэргэжлээр системтэй сургаж байна. Кибер аюулгүй байдлын инженер мэргэжил бол дэлхийд хамгийн ховор, эрэлттэй мэргэжлүүдийн тоонд орчихсон, их үнэтэй, энэ төрлийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, зах зээлээс татан ажиллуулахад их төвөгтэй болсон. Тэгэхээр бид байгаа цэргийн алба хаагчдаа давтан сургах замаар боловсон хүчнээ хангана гэсэн бодлоготойгоор хүмүүсээ бэлтгэж байна. 2020-2025 он хүртэлх таван жилийн хөтөлбөр хэрэгжинэ. Энэ хугацаанд бид дэлхийн жишигт хүрсэн кибер аюулгүй байдлын нарийн мэргэжилтнүүдээр өөрсдийгөө хангах том зорилготой ажиллаж байна.

## ТӨЛӨВЛӨЛТИЙН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛЖ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮНГ НЭМЭГДҮҮЛЭХЭД АНХААРЧ АЖИЛЛАНА

(Түрүүч нь I нүүрт)

**Дээрх шинээр батлагдсан журмуудыг үйл ажиллагаандаа мөрдсөнөөр гарах үр дүнгийн талаар тодруулахгүй юу?**

-Төсвийн шууд захирагч нар болон албан тушаалтнуудын ажлын хариуцлагыг өндөржүүлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх агентлаг, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөвлөлт, үйл ажиллагааны харилцан уялдааг сайжруулах, хэрэгжилт, үр дүнг нь нэмэгдүүлэхэд түлхэц болох юм. Мөн "Хэмжил зүйн тухай" Монгол Улсын хууль болон "Батлан хамгаалахын хэмжил зүйг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Батлан хамгаалахын сайдын А/241 дүгээр тушаалыг хэрэгжүүлж, цэргийн хэмжил зүйн хөгжлийг орчин үеийн түвшинд хүргэх, эталон хэмжих хэрэгслийг нэмэгдүүлэх, цэргийн хэмжил зүйн хангалтын асуудлаарх албан тушаалтнуудын эрх, үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, зохицуулахад "Зэвсэгт хүчний хэмжил зүйн дүрэм" нь чухал ач холбогдолтой баримт бичиг юм. Мөн энэхүү баримт бичиг батлагдсанаар зэвсэглэл, цэргийн техникийг шалган баталгаажуулах, зориулалтаар нь осол, гэмтэлгүй ашиглах, бүх төрлийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой. Түүнчлэн "Цэргийн хэмжил зүй" хичээлийг анх удаа ҮБХИС-ийн сургалтын хөтөлбөрт заавал судлах хичээлийн нэг болгож, сургалтын хөтөлбөрүүдэд нь тусгаж шийдвэрлүүлснээр ҮБХИС-ийг төгсөгчид хэмжил зүйн талаар тодорхой ойлголттой болж, хэмжих үйл ажиллагаа бодит ажил болж биеллээ олох ач холбогдолтой юм.

**Салбарын хэмжээнд хэрэгжүүлээд байгаа ажлуудаас гадна улсын хэмжээнд хэрэгжих олон баримт бичгүүдийг боловсруулсан. Энэ тухайд ...**

Тус газар нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг нь хангах талаар холбогдох байгууллага, албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлж ажилласнаар "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл" баримт бичгүүдэд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг тогтоосон хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулж байна. Мөн "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" баримт бичгийн төслийг боловсруулахад Батлан хамгаалах салбараас өнгөрсөн 25 жилийн хугацаанд дэвшүүлсэн зорилго, бодлого дэйл ажиллагаа, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд дүн шинжилгээ хийж, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар дүгнэлт хийж ажиллалаа.

Салбарын чиг үүргийн шинжилгээ, дахин хуваарилах ажлыг зохион байгуулж, Монгол Улсын холбогдох хуулиудаар Батлан хамгаалах чиглэлээр хүлээлгэсэн ерөнхий болон дэд чиг үүргүүд, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн жагсаалтыг нарийвчлан гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнасан. Энэхүү чиг үүргийн шинжилгээнд үндэслэн яамны бүтцийн нэгжүүдийн ажлын байрны уялдаа холбоо, ажлын байр бүр хуулиар хүлээлгэсэн тодорхой дэд чиг үүргийг хэрэгжүүлэхээр байгуулагдсан эсэхэд шинжилгээ хийж, бүтцийн нэгжүүдэд зөвлөмж өгч ажиллалаа.

**Нийт ажлыг багцлан дүгнээл хэдэн хувийн биелэлттэй гарч байгаа вэ?**

-Батлан хамгаалах яамны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал тутам явцын үнэлгээ хийж, хэрэгжилтийг нь эрчимжүүлэх талаар бүтцийн нэгжүүдийг зөвлөмж, мэдээлэлээр тогтмол хангаж ажилласнаар "Яамны календарчилсан төлөвлөгөө"-ний хэрэгжилт 97,7 хувьтай байлаа. 2019 онд Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт болон төрийн өмчит 16 аж ахуйн нэгж, анги, байгууллагад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийж, Монгол Улсын хууль, тогтоомж, Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар батлагдсан дүрэм, журам, заавар, норм, стандартын хэрэгжилт, гадаадын тусламж, төрийн өмч, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, дотоод хяналт шалгалтын талаар үнэлэлт, дүгнэлт өгч, зөрчил, дутагдлыг таслан зогсоох, үйл ажиллагаагаа хуулийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлэх талаар заавар, зөвлөмж өгч ажилласан. 2018 онд шалгалтад хамрагдсан анги, байгууллагуудад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 73 хувь, улсын ахлах байцаагчийн акт, албан шаардлагын биелэлт 83 хувьтай байлаа. Тус газар хяналт шалгалтын зэрэгцээ төсвийн шууд захирагч, санхүү бүртгэлийн ажилтнууд, удирдах албан тушаалтнуудад эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар ажлын байрны сургалтыг тогтмол явуулж, нийт 12 анги, байгууллагын 254 хүнд мэргэжил, арга зүйн заавар, зөвлөгөө өгсөн байна. Мөн Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлан, мэдээ хариуцсан болон санхүү бүртгэлийн ажилтнуудтай "Дотоод хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалт зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлэхэд дотоод хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах талаар үүрэг, чиглэл өглөө.

Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт болон төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд 2019 онд хийсэн хяналт шалгалтын дүнгээс үзэхэд шалгалтад хамрагдсан анги, байгууллагуудын тоо нэмэгдсэн хэдий ч илэрсэн зөрчил, дутагдлын тоо, хэмжээ багассан нь тус газрын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаа нь зохих үр дүнгээ өгч байна гэж дүгнэж болохоор байгаа юм.

**Энэ оны ажлын онцлогийн хувьд ...**

-2020 онд үйл ажиллагааны төлөвлөлт, түүний уялдаа холбоог сайжруулж, гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлэх, түүнчлэн төсөв, төрийн өмч хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг удирдлагаар хангахад төсвийн шууд захирагч нарын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, харьяа төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирагчийн анх томилоход нь төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн талаар анхан шатны мэдлэг олгох сургалтад заавал хамруулагдах болох зохицуулалтын арга хэмжээг авах, "Батлан хамгаалахын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын 2020-2022 оны дунд хугацааны стратеги"-ийг боловсруулан батлуулахаар тус тус төлөвлөн ажиллаж байна.

# КОРОНАВИРУСИЙН ТАРХАЛТ ЭРСДЭЛТЭЙ ХЭВЭЭР БАЙГААГ АНХААРАХ ХЭРЭГТЭЙ

Сүүлийн үед Зэвсэгт хүчний анги, салбаруудад "COVID-19"-ийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж байгаа ажлуудын талаар ЗХЖШ-ын Ар талын газрын Эрүүл мэндийн хангалтын хэлтсийн дарга, хурандаа Л.ГАНЧИМЭГЭЭС тодрууллаа.

**Зэвсэгт хүчний анги, салбаруудад коронавирүсийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар ямар ажил хийж байгаа талаар мэдээлэл өгөхгүй юу?**

-Бие бүрэлдэхүүнийг "COVID-19"-ийн болон бусад амьсгалын замын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд шаардлагатай самбай даавууг хуваарийн дагуу олгон амны хаалтын хүрэлцээг нэмэгдүүлж, нөөцийг бүрдүүлэн бэлэн байдлыг ханган ажиллахыг нийт нэгтгэл, ангийн захирагч, эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгож, хяналт тавин ажиллаж байна. Мөн ариутгал, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын материал хэрэгслийн тодорхой нөөцийг бүрдүүлсэн. ЗХЖШ-ын шалган нэвтрүүлэх байранд зайнаас халуун хэмжигч, гар ариутгагч бодис зэргийг байрлуулан бие бүрэлдэхүүний халууныг хэмжиж, гарыг ариутгуулан, амны

хаалтгүй бие бүрэлдэхүүнийг нэвтрүүлэхгүй байх шаардлага тавин ажиллаж байна.

**Цаг үеийн шинэ мэдээлэл болон ариутгал, халдваргүйтгэлийн ажлууд хэрхэн хийгдэж байгаа талаар ...**

-Коронавирүсийн тархалт эрсдэлтэй хэвээр байгааг анхаарах хэрэгтэй. Тиймээс Зэвсэгт хүчний Жанжин штаб, Агаарын цэргийн командлалд "COVID-19"-ийн халдварын нөхцөл байдал, цаг үеийн үнэн зөв мэдээллийг цахимаар болон мэдээллийн самбарт байрлуулах ажлыг тогтмолжуулан, жижүүрийн байруудад жавелины 20 литрийн баллонтой уусмалыг байрлуулан гадаргуугийн ариутгал, халдваргүйтгэл хийх шүршдэг саваар хангаж, ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийж байна. Түүнчлэн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд хөдөлгөөнт эмнэлгийн бүлгийг томилгоожуулан үзлэг,



ариутгал хийх цэгийг Дорноговь аймгийн Зүүнбаян баг, Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг дэвсгэрт дэлгэн байгуулж, эрүүл мэндийн үзлэгийг тогтмолжуулж, авто техникт ариутгал, халдваргүйтгэлийг хийж байна.

Зэвсэгт хүчний Жанжин штабын Ар талын газрын даргын баталсан удирдамжийн дагуу шинэ коронавирүсийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн

хэрэгжүүлж байгаа болон сэтгэлтэй тохиолдол гарсан үед тусгаарлах өрөө, халдвар хамгааллын хувцасны бэлэн байдал, Эрүүл мэндийн сайдын тушаалууд, Эрүүл мэндийн хангалтын хэлтсийн даргын заавар, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, дутагдлыг арилгуулах зэрэг ажлыг Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, ангиудад явуулан үүрэг, зааварчилгаагаар ханган

ажиллаж байна. Мөн Зэвсэгт хүчний Улаанбаатар цэргийн хүрээний анги, байгууллагуудын бие бүрэлдэхүүний 2020 оны урьдчилан сэргийлэх үзлэгийг Цэргийн төв эмнэлгийн томилгоот эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээр тухайн нэгтгэл, анги, байгууллагын эмнэлгийн байрыг нь түшиглэн хөдөлгөөнт хэлбэрээр зохион байгуулан хяналт тавин ажиллаж байна.



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХЗЦ-ИЙН КОМАНДЛАЛААС МЭДЭЭЛЖ БАЙНА

## Ж.Батжаргал: ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫГ БҮХ ТАЛААР ДЭМЖИЖ АЖИЛЛАНА



Төв аймгийн Засаг дарга Ж.БАТЖАРГАЛТАЙ цаг үеийн асуудлаар ярилцлаа. Тэрээр Зэвсэгт хүчин нь эх орноо батлан хамгаалах үндсэн үүргээсээ гадна иргэдийг чадамжтай бие хүн болгон төлөвшүүлэхэд түүхэн гавьяа байгуулж буйг онцолж байсан юм.

**Төв аймгийн хэмжээнд хаваржилт ямархуу түвшинд байна вэ гэдгээс ярилцлагаа эхэлж ...**

-Төв аймаг бол Монгол Улсын эдийн засгийн том бүс нутаг. Аймгийн маань эдийн засгийн үндсэн салбар нь мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл бөгөөд энэ цаг үед хөдөө аж ахуйн ажлууд ид өрнөж байна. Аймгийн нийт нутгаар өнтэй сайхан өвөл болж өнгөрсөн ч тал хээрийн бүс нутагт бэлчээрийн хортон мэрэгчдийн тархац их, ургамлын гарц муу байгаагаас хаваржилт хүндрэх төлөвтэй байна. Энэ утгаараа аймгийн удирдлага болон Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас мал төлөвлөлийн бэлтгэл ажлыг нэлээд чамбайруулж, хүндрэх төлөвтэй байгаа бус нутаг руу тухайлсан арга хэмжээг авч байгаа юм. Аймгийн хэмжээнд өөрсдийн хөрөнгө оруулалтаар 100 гаруй мянган га газарт үлийн цагаан оготно устгах ажлыг ид явуулж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас мөн 100 гаруй мянга га газарт үлийн цагаан оготно устгах ажлын хөрөнгө, санхүүг нь шийдвэрлэж өглөө. Энэхүү ажлыг ойрын хугацаанд зохион байгуулна.

Энэ онд газар тариалангийн хувьд, нэгэн шинэ жаран эхэлж байгаа бөгөөд тэр нь атрын дөрөвдүгээр аян. Нэлээд завсардсан атрын аяныг эхлүүлж буйгаараа онцлог жил гэж ойлгох хэрэгтэй. Газар тариалангийн үйлдвэрлэлээрээ улсдаа тэргүүлэгч, анхдагч аймгийн хувьд энэхүү аянд манлайлан оролцож таарна. Энэ жил 90 гаруй мянган га газарт үр тариа, найман мянган га газарт төмс, 1700 га газарт хүнсний ногоо, 10 гаруй мянган га газарт малын тэжээлийн ургамал тариалах зорилттой. Энэхүү зорилтыг хангах хүрээнд тариалантын штабыг байгуулан шуурхайлуулж, сумдынхаа тариалантын штабуудыг мөн ажилд нь орууллаа. Үр тарианы хувьд зургаан мянган тонн үр дутагдаж байгаа. Үүнийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих сангаас татан авч, тариалантаа бүрэн хийх зорилт тавин ажиллаж байна. Засгийн газраас зарласан атрын дөрөвдүгээр аян эхэлж байгаатай холбогдуулаад үр тариа, төмс, хүнсний ногооны тариалалт, ургацын хэмжээг нэмэгдүүлэх, газар тариалангийн бүтээгдэхүүнээр өөрийнхөө хэрэгцээг бүрэн хангах ажлыг эхлүүлээ. Өмнөх жилүүдтэй харьцуулахад тариалах талбай, хэмжээ нэмэгдэнэ. Тариалантынхаа бэлтгэл ажлыг хаа хаанаа нэлээд эрчимжүүлж байна даа.

**Мал төлөвлөлийн тухайд ...**

-Энэ жил аймгийн хэмжээнд 2,3 сая мал төлөх ёстой. Одоогийн байдлаар 30 орчим хувь нь төлөссөн бөгөөд гарсан төлийн бойжилт 98,7

хувьтай байна.

**Орон нутгийн удирдлага, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын харилцаа, хамтын ажиллагаа өргөн хүрээнд, тогтвортой явагдаж ирсэн уламжлалтай. Өнгөрсөн жилээс тухайн нэгтгэл, ангиудын цэргийн захиргааны байгууллага болох Хуурай замын цэргийн командлал шилжин байрлалаа. Үүнийг дагаад орон нутагт нэлээдгүй ажлын байр бий боллоо ...**

-Улс орны хамгийн амин чухал зүйл нь бүрэн эрхт тусгаар тогтнолоо бататган хамгаалах тухай асуудал юм. УИХ-аас улс орныг батлан хамгаалах бодлогын тулгуур зарчим нь орон нутгийн хамгаалалт гэж үзээд орон нутгийн хамгаалалтын эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгснийг та бид мэднэ. Энэ хүрээнд орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулан Батлан хамгаалахын сайдаар батлуулан ажиллаж байна. Төв аймаг нь Улаанбаатар хотыг өөрийнхөө нутаг дэвсгэрт багтаасан байршилтай. Тийм ч учраас нийслэл болон төвийн бүсийн аюулгүй байдлыг хангах нь орон нутгийнхан бидний үүрэг гэж ойлгож болно. Төв аймгийн нутаг дэвсгэрт Зэвсэгт хүчний цөөнгүй нэгтгэл, анги, салбар үйл ажиллагаагаа явуулдаг. Зэвсэгт хүчинтэй нягт хамтран ажилладаг байдлаараа манай аймаг тэргүүлэгчдийн тоонд багтдаг. Өнгөрсөн жилээс Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал хэмээх энэ их том айлаар хүрээгээ тэлсэндээ орон нутгийнхан бид баяртай байгаа. Өнгө зүстэй барилгаасаа эхлээд л орон нутагт чимэг болж байгаа командлалтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, орон нутгийн хамгаалалт, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд арга зүй, заавар, зөвлөмжийг нь авч ажиллана. Мэдээж цэргийн захиргааны энэхүү том байгууллагын алба хаагчдын ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог нь хангаж, тодорхой дэмжлэг үзүүлэх нь орон нутгийн удирдлагын үүрэг юм. Тиймээс командлалын албан тушаалын орон сууцны асуудалд тодорхой дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Цаашдаа орон нутаг, командлал хоёр нягт хамтран ажиллаж, улс орныг батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, иргэдийг эх оронч үзэл, хүмүүжлээр төлөвшүүлэх, улс үндэстнийхээ тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангахад иргэдийн ухамсрыг дээшлүүлэхэд чиглэсэн олон ажил, арга хэмжээг зохион байгуулна. Ер нь Төв аймаг нь Зэвсэгт хүчний түүхэнд томоохон үүрэг гүйцэтгэсэн нутаг юм. Дайн, тулгаралтад ард иргэдээ илгээж байсан алдар түүхтэй аймаг. Хамгийн наад захын жишээ

гэхэд, БНМАУ-ын баатар гурав мөн 10 гаруй генерал төрсөн. Ахмад үеийнхээ баатарлаг, дайчин, эх оронч замнал, үйл ажиллагааг нь хойч үеийнхэндээ сурталчлан таниулах, тэднийг эх оронч хүмүүжлээр төлөвшүүлэх, бахархлыг нь төрүүлэх үйл ажиллагаа руу чиглэсэн олон арга хэмжээг БХЯ, ЗХЖШ, Хуурай замын цэргийн командлалтайгаа хамтран зохион байгуулж ирсэн. Эдгээр ажлуудаа ирэх жилүүдэд улам өргөжүүлнэ. Энэ бол мэдээж нийгэмд хандсан ажил. Харин хоёр дахь хэлэх санаа гэвэл Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад цэргийн гэрээт алба хаагч болоод үйлчилгээний албаныхан нь голчлон орон нутгийн иргэд байдаг. Энэ утгаараа орон нутагт хэзээнээсээ л ажлын байрыг бий болгосор ирсэн. Командлал ч ялгаагүй цөөнгүй ажлын байрыг бий болгон, орон нутгаас иргэдийг сонгон шалгаруулж авсан нь бас нэгэн нийгмийн хариуцлага юм. Ер нь ч цэрэг армитай холбоотой сайн жишээ, сайн үйлс дэндүү олон доо.

**Жишээлбэл ...**

-Төв аймгийн эдийн засгийн үндсэн салбар нь хөдөө аж ахуй бөгөөд үүнтэй холбоотой томоохон ажил, арга хэмжээг нугалж, ард нь гарахад Зэвсэгт хүчин үргэлж тусалж, дэмжиж ирсэн. Мөн Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин нь эх орноо батлан хамгаалах их үйлс, үндсэн үүргээсээ гадна залуусыг амьдрах чадвартай бие хүн болгон төлөвшүүлэхэд онцгой гавьяа байгуулж ирснийг дурдах ёстой. Учир нь цэргийн алба хаасан иргэдийг бусад салбарууд ажилд авахдаа тун дуртай байдаг шүү дээ. Шалтгаан нь эдгээр хүмүүс тодорхой хэмжээнд бэлтгэгдсэн байхаас гадна үг даах чадвартай болж, хамт олны дунд биеэ зөв авч яваад төлөвшчихдөг. Бас амьдралд тохиолдсон сайн, муу сорилтыг даван туулах сэтгэлийн хат, тэсвэр, тэвчээртэй болдог нь олон жишээнээс тод харагддаг юм. Тэгж байж ч энэ цаг үед сайхан амьдрах бололцоо бүрдэнэ л дээ. Жижигхэн юмны өмнө бөхийгөөд байвал сайхан амьдарна гэдэг тун төвөгтэй. Тийм учраас манай Зэвсэгт хүчин алба хаагчдаа зөв төлөвшилтэй хүн болгох том сургуулилтаар давхар бэлтгэж байгаад иргэн хүний хувьд ч, орон нутгийн удирдлагын хувьд ч баяртай явдаг юм.

**Аймгийн Засаг дарга нар 2020-2021 онд Батлан хамгаалахын сайдтай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Энэ гэрээнд ямар ажлууд тусав, хэрэгжилт ямар түвшинд явагдаж байна вэ?**

-Батлан хамгаалахын сайдтай хамтран ажиллах болоод төрийн зарим чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх талаар гэрээ байгуулсан. Үүнд, цэрэг татлагын асуудлыг орон нутагт чанартай зохион байгуулах, бэлтгэлд байгаа цэргийн алба хаагчдыг сурган дадлагажуулах, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, томилгоот бүрэлдэхүүнийг сургах, шаардлагатай нөөц бүрдүүлэлтийг

шийдвэрлэх зэрэг олон ажлууд тусгагдсан. Эхнээсээ хэрэгжээд явж байна. Батлан хамгаалахын сайд Н.Энхболд нь Төв аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн бөгөөд орон нутгийнхаа төлөө олон жил зүтгэж яваа төрийн түшээ юм. Төрийн болон олон нийтийн байгууллагын хөгжлийг хангах, бүтээн байгуулалтыг дэмжихэд оруулсан түүний хөдөлмөр, зүтгэл их юм. Орон нутгаас олон ажил хэрэгжүүлж байгаагийн нэг нь номын сан. БНСУ-ын хөрөнгө оруулалтаар бүрэн засварлаж, нэг дүр төрх, шинэ менежмент, шинэ үйлчилгээг бий болгох боломж удахгүй бүрдэнэ. Хоёрдугаарт, Сөүл хотын их сургуулийн салбар сургуулийг гадаадад, тэр дундаа Монгол Улсад, бүр тодруулбал, Төв аймагт анх удаа байгуулах асуудлыг шийдвэрлүүлж чадсан. Энэ оноос эхэлж сургууль байгуулах төлөвлөлт гээд бүх зүйл нь хийгдэнэ. Ингэснээр дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн боловсролыг Монголдоо эзэмшиж, гадаадын аль ч оронд очиж ажиллах бололцоо нь бүрдэж байгаа юм. Үүгээр дамжуулж дээд боловсролын сургалтын чанарт том өөрчлөлт авчирна гэж харж байна.

**Хуурай замын цэргийн командлалтай ямар чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөтэй байгаа вэ?**

-Мэдээж бид бүхэн Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. Зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд нь, орон нутагт маань үйл ажиллагаа явуулж байгаагийнх нь хувьд дэмжиж ажиллах ёстой. Хоёрдугаарт, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилтуудыг хангахад тодорхой хэмжээнд хамтран ажиллана. Гуравдугаарт, орон нутгийн хамгаалалтын шинэ тогтолцоог хөгжүүлэх, бодит ажил болгоход командлалын мэргэжил, арга зүйн удирдлага бидэнд их чухал. Түүнээс гадна манай Зэвсэгт хүчин төмөр замын томоохон бүтээн байгуулалтын ажилд оролцож эхлээд байна. Цаашдаа манай Зуунмод хот хөгжлийн хамгийн том бүс нутаг болно. Учир нь олон улсын нисэх буудал баригдчихлаа. Одоо төмөр зам, Авто, Европыг холбосон хатуу хучилттай авто зам, бусад томоохон бүтээн байгуулалт яригдаж байна. Энэ бүхэнд бүтээн байгуулагч цэрэг дайчдын оролцоо асар их юм. Орон нутгийн хувьд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалтай өргөн хүрээнд хамтарч, бүх талаар нь дэмжлэг үзүүлж ажиллана.

**Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА**

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ ХИЛИЙН ЧАНАДААС МЭДЭЭЛЖ БАЙНА

# ЭРҮҮЛ БАЙНА ГЭДЭГ ХУВЬ ХҮНИЙ УХАМСАР, ТӨЛӨВШИЛТЭЙ ШУУД ХОЛБООТОЙ

БНӨСУ-ын нийслэл Жуба хотод энэ сарын 5-ны өдөр дэлхий нийтийг донсолгоод байгаа халдварт цар тахал болох коронавирусын халдвар авсан нэг тохиолдол илэрснийг тус улсын Дэд ерөнхийлөгч Р.Мачар албан ёсоор мэдэгдээд байгаа билээ. Аюул занал хаяанд тулсан эрсдэлтэй энэ цаг үед цэргийн багийн бие бүрэлдэхүүн энэхүү вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа талаар Цэргийн багийн эмнэлгийн бүлгийн дарга, мэс заслын их эмч, ахмад А.ГАНБАТТАЙ ярилцсанаа хүргэе.

вирус улам идэвхжинэ гэсэн судалгаа гарсан учраас тэдгээр саруудад ариутгалыг түлхүү хийнэ. Энэ дашрамд, вирусийн халдвар дэлхийд тархаж эхлэхтэй зэрэгцэн цэргийн баг шуурхай арга хэмжээ авч угаалга цэвэрлэгээ, ариутгалын бодисоо гурван сарын эхээр татан



**Юуны өмнө та дэлхий нийтийг цочроогоод буй цар тахлаас урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээнүүдийг батальоны хэмжээнд өрнүүлж буй талаар мэдээлэл өгнө үү?**

-Тус вирусийн халдвар бидний үүрэг гүйцэтгэж буй улсын нийслэлд илэрсэн нь албан ёсоор тогтоогдлоо. Тэгэхээр бид нэн тэргүүнд урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайтар авахаас өөр аргагүй. Хүн бүхэн дор бүрнээ анхаарал болгоомж, ухамсар, хариуцлагатай байж, хувийн ариун цэврийг сайтар сахихаас эхлээд байж болох бүхий л арга хэмжээг авах ёстой. Бид бие бүрэлдэхүүнд энэ чиглэлийн сургалт, зөвлөмжүүдийг хүргэх, эрүүл мэндийн боловсролыг нь дээшлүүлэхэд анхаарч байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Монгол Улсын Эрүүл мэндийн яам, "UNMISS" ажиллагааны эмнэлгийн бүлгээс гаргаж байгаа заавар, зөвлөмжүүдийг цаг алдалгүй судалж, бие бүрэлдэхүүнд зургаан удаагийн зөвлөмж, гурван удаагийн видео танилцуулгыг хүргэсэн. Энэхүү вирусийн шинж чанар асар богино хугацаанд хувьсан өөрчлөгдөж, илрэх шинж тэмдэг нь өөр өөр байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас мэдээлж байна. Тиймээс үүнтэй уялдан заавар, зөвлөмжүүдийг аль болох цаг алдалгүйгээр судалж, үүрэг гүйцэтгэлтийн онцлог, нөхцөл байдалтай уялдуулан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авах ёстой. Тийм ч учраас эмнэлгийн бүлэг дотооддоо долоо хоногт дөрвөн удаагийн сургалтыг зохион байгуулан шинэ мэдээ, мэдээлэл, заавар, зөвлөмжүүдийг боловсруулж байна. Цэргийн алба хаагч тус бүрд гурван ширхэг амны хаалтыг оёулж тараасан. Ямар хугацаанд сольж ариутгах ёстойг ч алхам тутамд нь зөвлөж байна. Үүнээс гадна баазын шалган нэвтрүүлэх цэгүүдэд сувилагч нар 06.00 цагаас

19.00 цаг хүртэл ажиллаж, орж, гарч байгаа цэргийн алба хаагчдын халууныг үзэж, гар ариутгал, халдваргүйтгэлийг хийж байна.

**Энд хамтран үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багуудын I, II шатны эмнэлгүүдийн эмч нар уулзалт хийж, уг вирусийн тархалтын үед хэрхэн хамтран ажиллах, урьдчилан сэргийлэх талаар ярилцсан. Энэ тухайд тодруулна уу?**

"UNMISS" ажиллагааны эмнэлгийн бүлгийн болон Монгол, Вьетнам, Гана, Энэтхэгийн цэргийн багийн эмч нар уулзалт хийж энэхүү тахлаас хэрхэн урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг гарган хамтран ажиллаж байна. Үүний нэг илрэл нь НҮБ-ын баазын төв хоёр хаалган дээр дээрх эмнэлгүүд ээлжлээд эмч, сувилагчийг томилон ажиллуулж, нэвтэрч байгаа хүмүүсийн халууны хяналтыг хийж байна. Урьдчилан сэргийлэх өвөрмөц сэргийлэлт байхгүй, эмчилгээний бэлдмэл гараагүй, илрэх шинж тэмдэг нь богино хугацаанд хувьсан өөрчлөгдөж, асар хурдацтай тархаж байгаа, зарим улсад нас барагсдын тоо хоногт хэдэн зуугаараа өсөж байгаа зэрэг нь энэхүү вирусийн аюул заналыг бэлхнээ харуулж байна. Тиймээс урьдчилан сэргийлэлт хамгийн чухал бөгөөд хүн бүхнээс дор бүрнээ хариуцлагатай байхыг шаардаж байна.

**Урьдчилан сэргийлэхийн тулд нэн тэргүүнд ариутгал, халдваргүйтгэлийг сайтар хийх шаардлагатай байх. Ариутгалын бодисын хүрэлцээ, нөөц хэр бий вэ?**

-Ариутгал, халдваргүйтгэл нь хамгийн чухал. Энгийн үед хийдэг байсан ариутгал х а л д в а р г ү й т г э л и й н давтамжийг 50-60 хувиар нэмэгдүүлсэн. Хэрэглээ ихсэж байгаа учраас дараа дараагийн саруудад хэрэглэгдэхээр тооцсон ариутгалын бодисоо нааш нь татаж хэрэглэнэ. Ялангуяа дөрөв, тавдугаар сард уг

авснаас гадна Жуба дахь хятад дэлгүүрээс алкохол өндөртэй хятад архийг худалдан авч ариутгалын зориулалт бүхий санитолыг дотооддоо хийх нөхцөлийг хангасан. Гэсэн хэдий ч энэ нь бидний хэрэгцээг бүрэн хангахгүй. Мөн вирусийг илрүүлэх түргэвчилсэн тест, тоног төхөөрөмж БНӨСУ дахь НҮБ-ын бүх шатны эмнэлэгт байхгүй. Тиймээс өвчин хүндэрч шинж тэмдэг илт илэрхий болохоос нааш илрүүлэх боломжгүй байна. Энэ нь өвчтөнийг тусгаарлах үед халдвар тархах нөхцөлийг бий болгож, нэмэгдүүлнэ гэсэн үг. Тэгэхээр бид урьдчилан сэргийлэх талаар онцгой анхаарах ёстой.

**Бид ажиллагааны газар оронд ирээд хагас жилийн хугацааг үдээд байна. Ер нь цэргийн алба хаагчдын эрүүл мэнд, дархлаа хэр байна вэ?**

-Бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн байдал харьцангуй сайн байгаа. Шүдний өвчлөл харьцангуй нэмэгдэх хандлагатай байгааг эс тооцвол анхаарал татсан янз бүрийн өвчлөл таатай байна. Цэргийн алба хаагчдад улирал тутамд эрүүл мэндийн үзлэг, оношилгоо хийхээр төлөвлөж, эхний үзлэгийг нэгдүгээр сард явуулсан. Дараагийн ээлжит үзлэгийг энэ сард явуулах ёстой. Гэвч энэхүү вирусийн халдвар, тархалттай уялдан хөл хорио тогтоож байгаагаас шалтгаалаад тодорхой хугацаагаар хойшлох төлөвтэй байгаа.

**Цэргийн багийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүрэлцээний тухайд тодруулбал ...**

-Зайлшгүй хэрэгцээ шаардлагатай тоног төхөөрөмжүүд хангалтгүй. Нэн тэргүүнд хүний эрүүл мэндийг бодох ёстой. Миний хувьд ч энэ талаар бодит байдлыг нь холбогдох албан тушаалтнуудад илтгэж, асуудлыг шийдүүлэхэд анхаарал хандуулна.

# МАЁМ, АБЬЕМНОМД ЭРГҮҮЛЭЭР...

БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний IX ээлжийн цэргийн багийн хариуцлагын бүс дэх Маёом болон Абыемном сум нь гэмт хэргийн гаралт, хүний эрх зөрчигдсөн үйлдлүүдээрээ бусад бүс нутгуудаас нэлээд дээгүүрт тооцогддог. Юнити секторын командлагчийн захирамжийг үндэслэн Цэргийн багийн захирагчийн тушаалаар эргүүлийн бүлэг томилогдон дээрх сумдад 3 дугаар сарын 23-31-ний өдрүүдэд үүрэг гүйцэтгэлээ.

Тухайн бүс нутаг НҮБ-ын цэргийн идэвхтэй үйл ажиллагаагаар энхийг сахиулагчдын хүчийг үзүүлэх, хүний эрхийн эсрэг хүчирхийлэл үйлдэгч этгээдүүдэд анхаарал,

суурингийн нутгийн удирдлагын байрыг засварласан нь тэдний талархлыг хүлээсний зэрэгцээ эргүүлийн бүлгийн үйл ажиллагааг нутгийн удирдлагын зүгээс бүхий л талаар дэмжих хөшүүрэг болсон.

Гуравдугаар сарын 28-ны өдөр Маёом суурингаас "Хубилай" баазаас 122 км километрт байрлах/ Абыемном сууринд шилжин байрлаж, орон нутгийн удирдлагатай уулзалт хийсэн бөгөөд эргүүлийн зорилго, үүргийн талаар танилцуулахын зэрэгцээ орон нутгийн аюулгүй байдлын нөхцөлд тулгамдаж буй асуудал, түүнд цэргийн багаас эергээр нөлөөлөх үйл ажиллагааны талаар санал солилцов.

Абыемном сууринд байрлах Өмнөд Суданы 3 дугаар дивизийн 7А бригадын захирагч, бригадын генерал Жи Житэй



болгоомж төрүүлэх замаар санаархлыг нь тасалдуулах, иргэдэд дарамт болж буй гэмт үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох нь энэ удаагийн эргүүлийн гол зорилго байв. Секторын командлагчаас өгсөн энэхүү үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан 3 дугаар сарын 12-ны өдөр туршуулын бүлэг томилж Маёом сумын Засаг дарга Петер Куртай уулзаж эргүүлийн бүрэлдэхүүний байрлах газар, усны эх булаг, аюулгүй байдлын орчин, эргүүлийн үед онцгой анхаарах бусүүдийн талаар мэдээлэл авч бэлтгэл ажлыг базаасан юм.

Эргүүлийн бүлэг эхний өдөр буюу 3 дугаар сарын 23-ны өдөр Маёом "Хубилай" баазаас баруун зүгт 82 километрт/ сууринд шилжин байрлаж төлөвлөгөөний дагуу тус сумын хойд хэсгийн тосгодоор эргүүлийн үүрэг гүйцэтгэв. Түүнчлэн Цэргийн багийн захирагч болон Эргүүлийн бүлгийн дарга 24-ний өдөр Маёом сумын Засаг даргын аюулгүй байдлын хуралд (Засаг дарга, цагдаагийн дарга, 1 дүгээр бригадын захирагч, үндэсний авулгүй байдлын албаны дарга нар оролцсон) оролцон тус хурлаас авсан мэдээлэл болон секторын штабаас ирүүлсэн мэдээлэл, удирдамжид үндэслэн эргүүлийн төлөвлөгөөнд тодотгол хийсэн ба 24-27-ны өдрүүдэд энгийн иргэдийн эсрэг гэмт хэрэг ихтэй Абей мужийн хилийн бүс Хамир, өмнөд хэсэг дэх Манкени, Засгийн газрын эсрэг хүчний тусгаарлах байр байрладаг Тумор тосгоноор хуягт тээвэрлэгчтэй өдөр, шөнийн эргүүлийн үүргийг гүйцэтгэсэн.

Эргүүлийн хугацаанд цэрэг, цагдаагийн удирдлагууд, иргэдтэй уулзалт хийж аюулгүй байдал, хүний эрх зөрчигдсөн үйлдэл, шалтгааны талаар мэдээллүүдийг олзворлон эргүүлийн мэдээг дээд штабт хүргэж ажиллалаа.

Үүрэг гүйцэтгэх хугацаанд цэргийн баг, орон нутгийн удирдлагын хоорондын харилцааг бэхжүүлэх, нутгийн удирдлага, иргэдэд монгол цэргийн үйл ажиллагааг дэмжих таатай сэтгэгдлийг төрүүлэх зорилгоор зэвсэгт мөргөлдөөний улмаас эвдэрч муудсан Маёом

уулзалт хийж хариуцлагын бүс дахь онцгой анхаарах районууд болон эргүүлийн үйл ажиллагаа, үр дүнг нь дээшлүүлэх талаар харилцан санал солилцсоны дүнд хамтарсан эргүүл хийх, онцгой анхаарах районуудад орон нутгийн удирдлагатай хийх уулзалтад генерал биечлэн оролцох санал тавьсныг хүлээн авч Мажок суурингийн чиглэлд хоёр удаа үүрэг гүйцэтгэж хамтран ажиллалаа.

Гуравдугаар сарын 28-31-ний өдрүүдэд Абыемном суурингаас хойд болон зүүн зүгт орших Авегажир, Авила, Вараб муж, Абыемном, Маёом сумын хилийн уулзвар дахь Мажок суурингуудад өдөр, шөнийн эргүүлийн үүргийг гүйцэтгэсэн. Эргүүлийн явцад Абыемномаас Маёомын гэмт этгээдүүдийн хулгайлсан өсөн тугал, 22 ямааг Мажок сууринд цэргийнхэн илрүүлэн хураан авсныг эздэд нь хүлээлгэн өгөх асуудлыг нутгийн захирагчдын төлөөлөгчидтэй хэлэлцэн зохицуулсан нь иргэдийн талархлыг хүлээсэн юм. Мөн цэргийн хүчний саатуулсан гэмт хэрэгт холбогдогчидтой уулзаж, Маёом сумын удирдлагад Абыемном руу чиглэсэн халдлагыг бууруулах талаар арга хэмжээ авахыг анхаарууллаа.

Энэ удаагийн холын эргүүл батальоны хариуцлагын бүсийн онцгой анхаарах район болох хамгийн их гэмт хэрэг, аллага, хүний эрх зөрчигдөж байгаа Абыемном, Маёом сумын засаг захиргааны нэгжийн удирдлагатай харилцан ажиллагааг ханган, орон нутгийн цэрэг, цагдаагийн бүрэлдэхүүн цэргийн багийн хөдөлгөөний саадгүй байдлыг хангах итгэлцлийг бий болгосноороо ач холбогдол өндөртэй байлаа. Мөн хариуцлагын бүс дэх алслагдсан болон зам харилцаа муугаас цэрэг, цагдаагийн хүчинг хүрэхэд хүндрэлтэй суурингуудаар өдөр, шөнийн эргүүлийг гүйцэтгэсэнээр иргэдийн НҮБ-ын энхийг сахиулагчдад итгэх итгэлийг дээшлүүлэн гэмт этгээдүүдэд цэргийн идэвхтэй үйл ажиллагааг харуулснаар элдэв хүчирхийлэлт үйлдлүүдийг багасгаж батальон тавигдсан үүргээ амжилттай гүйцэтгэлээ.

Ахмад Д.МЭНДБАЯР

ТҮҮХИЙН ХАРГУЙ

# Н.Эрдэнэ-Очир: ТОНУУЛЧДААС БОЛЖ МАШ ИХ МЭДЭЭЛЭЛ УЛ МӨРГҮЙ АРИЛДАГ

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга,  
доктор Н.ЭРДЭНЭ-ОЧИРТОЙ ярилцлаа.

**Археологийн ажлын нийгэмд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар мэдээлэл хүргэхгүй юу?**

-Археологи бол хүн төрөлхтний олон мянган жилийн түүхийг сэргээн босгоход бодит олдвор, хэрэглэгдэхүүнд тулгуурлан түүхэн үнэнийг өгүүлдэг шинжлэх ухаан юм. Өөрөөр хэлбэл, археологийн малтлагаас илэрсэн бодит олдвор дээр үндэслэн судалгаа хийгддэг. Энэ утгаараа хамгийн үнэн бодитой үндэслэлийг дэвшүүлж, дүгнэлт хийдэг шинжлэх ухаан гэж хэлж болно. Мэдээж хэрэгнийгэмд маш чухал үүргүүд гүйцэтгэнэ. Тухайлбал, өнөөгийн монгол нутаг археологийн дурсгалаар нэн баялаг, олон улсын судлаачдын анхаарлыг ч ихээхэн татдаг. Төв Азийн энэхүү өндөрлөгөөс нүүдлийн соёл иргэншил бий болж, төрт улс үүсжээ. Монгол нутагт оршин тогтносон төрт улс бүр Евроазийн газрын зургийг өөрчилсөн байдаг. Энэ бүхнийг өгүүлэх археологийн дурсгалаа илрүүлэн судлах, олон улсын түвшинд гаргах, хадгалж хамгаалах, дэлхийн өвд бүртгүүлэх, хот суурин, уул уурхай, бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай зөв зохиотой уялдуулах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох, соён гэгээрүүлэх гэх мэт орхиуулаж боломгүй олон чухал үүргийг нийгэмд археологийн салбар гүйцэтгэдэг.

**Археологийн судалгаа Монгол оронд хэдий үеэс эхэлсэн бэ?**

-Анхны судалгаа XVIII зууны үед холбогдох бөгөөд Хархорум, Эрдэнэуу хийдийн хөшөө чулуунаас хэв хуулга авсан тухай их хүрээний сайдын илгээсэн баримт бичиг архивд хадгалагдаж байна. 1870 оноос Оросын судлаач И.В.Падерин, А.М.Позднеев, Н.М.Ядринцев, Г.Н.Потанин, В.В.Радлов, Д.А.Клеменц, П.К.Козлов, мөн Финляндийн эрдэмтэн Г.Гейкел, Г.И.Рамстед, И.Г.Грано, Японы эрдэмтэн К.Отани, Польшийн эрдэмтэн В.Л.Котвич, Америкийн эрдэмтэн Р.Ч.Эндрюс, Н.К.Нельсон зэрэг эрдэмтдийн удирдсан судалгааны багууд Монголын нутгаар аялж археологийн дурсгалуудтай танилцан, анхны малтлага, тодорхойлолт, тэмдэглэлийг тайлагнан бичиж, судалгааны эргэлтэд оруулсан байдаг.

Улмаар Монгол Улсын Ардын Засгийн газар 1921 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр өнөөгийн Шинжлэх ухааны академийн эх суурь "Судар бичгийн хүрээлэн"-г байгуулж эртний түүхийг судлах, дурсгалуудыг илрүүлэх, мэдээ цуглуулах ажлыг эрхлэх болж, 1924 оны 8 дугаар сарын 7-ны өдөр өнөөгийн "Соёлын өвийг хамгаалах тухай" хуулийн анхны эх болох "Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм"-ийг баталсан. Хүрээлэнгийн ажилтнаар О.Жамьян, Ж.Цэвээн, Н.Дэндэв нар мөн зарим Зөвлөлтийн судлаачид ажиллаж байв. 1950-иад оноос археологийн үндэсний боловсон хүчин бий болсон бөгөөд Ц.Доржсүрэн, Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав, Д.Дорж, Д.Наваан, Д.Цэвээндорж, Д.Баяр, Г.Мэнэс, З.Батсайхан зэрэг олон археологичдыг дурдаж болно. 1961 оны 10 дугаар сарын 13-ны өдөр БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академийг байгуулахад өмнө нь "Түүх-эдийн засгийн судлах газар" нэртэй байсан эрдэм шинжилгээний байгууллага нь Түүхийн

хүрээлэн болон өргөжиж Шинжлэх ухааны академийн үндсэн хэдэн хүрээлэнгийн нэг болон зохион байгуулагдсан байдаг. Тус хүрээлэнгийн анхны гурван нэгжийн нэг нь Археологи-этнографийн тасаг бөгөөд даргаар нь доктор Н.Сэр-Оджав ажиллаж байв. Улмаар 2019 онд Археологийн хүрээлэн нь Түүхийн хүрээлэнгээс өрх тусгаарлан байгуулагдаж бие даасан үйл ажиллагаа явуулж байна. Өдгөө 40 гаруй эрдэм шинжилгээний ажилтантай, гадаадын 10 гаруй орны 20 орчим хүрээлэн, их сургуулиудтай идэвхтэй хамтын ажиллагаа явуулж байна.

**Орон нутгийн иргэдийн сүсэг бишрэлээс бодлод түүхийн олдворууд хөрсөн дээр ил гарч чадахгүй байх тохиолдол бий. Энэ нь археологийн хөгжил, баяжилтад сөргөөр нөлөөлөх үү?**

-Эртнээс монголчууд хот балгадын туурь, булш, хиргисүүрийн ойр явах, ухаж хөндөхийг цээрлэж ирсэн уламжлалтай. Энэ нь нэг талаасаа эртний түүх, соёлын дурсгалаа хадгалж, хамгаалах арга ухааны нэг хэлбэр юм. Нөгөө талаар, археологийн дурсгалыг нэгэн зууны хугацаанд судалж дуусахгүй бөгөөд судалгааны зэрэгцээ, хадгалж, хамгаалах ажлуудыг цаг алдалгүй хийж гүйцэтгэх, хойч үеийн археологичдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай юм. Техник, технологи хурдтай хөгжихийн хэрээр ирээдүйд илүү нарийвчилсан судалгаа явагдах нь тодорхой. Тэр үед бидний судалгаа өмнөх үеийн судлаачдын адил суурь судалгаа болох нь дамжиггүй юм. Ийм залгамж халаатай ч явж ирсэн байдаг. Иймээс орон нутгийн иргэдийн энэхүү үзлийг сайшаах нь зүйтэй. Биет өв соёлоо хадгалж байгаа нэг хэлбэр юм.

**Гаднын орнууд шинжлэх ухааныхаа салбар их санаа тавьдаг. Монгол Улсын хувьд энэ тал дээр анхаарал хэр хандуулж байна вэ?**

-Өнөөдрийн байдлаар Археологийн хүрээлэн суурь судалгааны гурван төсөл, гурван хавсарга төслийг БСШУСЯ, ШУА, ШУТС-ийн дотоодын санхүүжилтээр хэрэгжүүлж байна. Жилийн нийт төсөв нь 40-50 сая төгрөгт багтана. Энэ бол харьцангуй бага тоо юм. Үүний хажуугаар гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиудтай хамтарсан археологийн судалгаа, төслүүдийг идэвхтэй явуулж байна. Зөвхөн улсаас, харьяа яамнаас өгсөн санхүүжилтийн хүрээнд ажлаа хийнэ гэвэл боломжгүй. Санхүүгийн дутагдлыг нөхөх үүднээс хамтарсан төслүүд дээр гаднын улс орнуудтай өргөн хүрээнд хамтарч ажилладаг. Мөн "Соёлын өвийг хамгаалах тухай" хуулийн хүрээнд археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааг гүйцэтгэж байна. Иймд дотоодын төсөл, үндэсний судалгаа, хүний нөөцийг бүрдүүлэх асуудлыг төрөөс бүх талаар дэмжиж ажиллах шаардлагатай.

**Олдворуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж хэр байдаг вэ?**

-Археологийн хүрээлэнд өөрийн гэсэн 8000 гаруй олдвор бүхий сан хөмрөг, лаборатори бий. Энэ бол манай байгууллагын үнэт өв гэж болно. Сэргээн засварлах лаборатори үйл ажиллагаагаа явуулж

байна. Мод, төмөр эдлэл, зарим органик эдлэл, ваар сав зэрэг олдворыг сэргээн засварлах, бэхжүүлэх ажлыг гүйцэтгэж байна. Зарим онцлог олдворууд нь Засгийн газрын тогтоолоор хосгүй үнэт олдворын жагсаалтад бүртгэгдсэн байгаа. Бид сан хөмрөгтөө тулгуурлан дотоодын болон гадаадын байгууллагуудтай хамтарсан эрдэм шинжилгээний үзэсгэлэнг идэвхтэй зохион байгуулж, сан хөмрөгийн хамгаалалт, орчин нөхцөлийг сайжруулах талаар анхаарч ажиллаж байна.

**Нийгмийн тогтолцоо өөрчлөгдсөний дараагаар боловсон хүчнийг бэлдэх асуудалд бүрэн реформ хийх нөхцөл бололцоо бага багаар бүрдэж эхэлсэн. Танай салбарын хувьд сүүлийн гучаад жил их өөрчлөлт, туршилттай нүүр тулсан он цаг байсан байх ...**

-Ардчилал гарч, зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш гадаад харилцаа идэвхтэй өргөжсөн. Манай улсын Археологийн шинжлэх ухаан ч бас шат ахисан, эрчимтэй судалгаа хийж эхэлсэн. Одоогийн байдлаар археологийн хүрээлэн нь 40 гаруй эрдэм шинжилгээний ажилтантай бөгөөд нэг академич, 17 доктор, 21 магистр зэрэгтэй судлаачид ажиллаж байна. Доктор, магиструудын 50 гаруй хувь нь гадаадын их сургуулиудад эрдмийн зэрэг хамгаалж, мэргэжил дээшлүүлсэн, 1-2 гадаад хэлтэй, хүний нөөцийн хувьд сайн бэхжсэн, чадварлаг хамт олноос бүрдэж байна. Мөн хүрээлэнгийн нэр дээр АНУ-д нэг, ХБНГУ-д нэг, БНХАУ-д гурав, Японд нэг, Солонгост нэг, дотоодын их сургуулиудад 13 хүн докторантурын сургалтад суралцаж байна. Зуны улиралд дотоодын болон хамтарсан 20 гаруй хэргийн шинжилгээний анги ажилладаг бөгөөд өндөр хөгжилтэй орнуудын судалгааны олон арга зүйн зангилаан дээр залуус маань суралцаж байна.

**Орхоны Шаамарын хөндийгөөс олдсон эртний хүний яс, Баянхонгор аймгийн Баянлигийн Цагаан агуйн олдвор зэргийг үндэслээд манай улсыг хүний үүслийн өлгий байж болох талтай гэж үздэг. Сүүлийн жилүүдэд энэ чиглэлийн судалгаанд ямар ахиц дэвшил гарсан бэ?**

-Чулуун зэвсгийн үеийн судалгаа олон жил тогтвортой явагдаж байна. Өнөөгийн Монгол Улсын нутагт одоогоос нэг сая орчим жилийн тэртээд эртний чулуун зэвсэгтэн оршин амьдарч байсныг археологийн судалгаагаар тогтоогоод байна. Монгол оронд явуулсан олон жилийн судалгааны үр дүнд Баянхонгор аймгийн Өлзийт сумын Нарийн гол, Баянлиг сумын Цагаан агуй, Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ярх уул, Өмнөговь аймгийн Булган сумын Цахиуртын хөндий, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхон, Мойлтын ам, Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаанхадны дурсгал гэх мэт эртний чулуун зэвсэгтний үл мөрийг хадгалал үлдсэн бууц, буудал, дархны газар, суурин 1000 гаруйг олж илрүүлсэн байна. 2006 онд Хэнтий аймгийн нутагт одоогоос 35 мянган жилийн тэртээд амьдарч байсан эртний хүний гавлын ясны чулуужсан хэсэг олдож "Монголын нэн эртний хүн" буюу "Mongolian anthropus" хэмээх нэрээр шинжлэх ухааны эргэлтэд орж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн юм. Булган



аймгийн нутаг Төлбөрийн голын савд Монгол-Орос-Америкийн хамтарсан судалгааны баг 2004 оноос өнөөг хүртэл тогтвортой судалгаа явуулж дээд палеолитын эхэн үеэс төгсгөл үеийг хамарсан 6-7 соёлт давхаргатай, түүхийн урт удаан хугацааны туршид хүн оршин амьдарч байсныг гэрчлэх олон зуун чулуун багаж зэвсгийн зүйлс бүхий 40 орчим дурсгалт газрыг нээн илрүүлж судалгааны эргэлтэд оруулсан зэрэг олон чухал үр дүнг дурдаж болно. Дээрх судалгаанууд нь Монгол орон хүй нэгдлийн үеийн голомт нутгуудын нэг мөн гэж үзэх үндэслэлтэйг батлан харуулж байна.

**Археологич мэргэжлийг эзэмшихэд хүний унаган зан чанар хэр нөлөөлдөг вэ?**

-Мэдээж оюутны ширээний араас судлаач хүн бий болно. Оюутны дөрвөн жил археологийн хэргийн судалгаанд оролцоно. Халуунд халж, хүйтэнд хөрч, өлсөж цангах, ядрах, цас бороо гэх мэт олон зүйл тохиолдоно. Хад чулуу зөөнө, биеийн хүчний ажил хийнэ гээд хүндхэн. Энэ үед хүний араар суух, ажлаас бултгах, хоолоо голох зэрэг янз бүрийн байдлаар хувь хүний зан чанар танигддаг. Эндээс тодорхой хэсэг нь тунан үлдэж, судлаач болон "үйлдвэрлэгдэж" байгаа юм. Манай археологичдын нэг давуу тал нь бүгд дээрх шүүлтүүрээр гарсан байдаг.

**Малтлагаас гарч ирсэн олдворуудаас мэдээллийг хэрхэн бүрдүүлдэг талаар сонирхуулахгүй юу?**

-Олдворууд археологийн малтлагаар илэрсэн байх ёстой. Малтлага нь сайтар баримтжуулалтын дор явагддаг. Хожим нь энэхүү баримтжуулалтад үндэслэн сэргээх боломжтой гэсэн үг. Хөрсний бүтцийг тодорхойлох, гар болон дэвсгэр зураг, гэрэл зураг, зүсэлтийн мэдээлэл гэх мэт олон төрлийн баримтжуулалтын дундаас археологийн олдвор илэрч олддог. Ийнхүү олдсон олдвороос судлан буй үеийн мэдээллийг авах бүрэн боломжтой бөгөөд үүгээрээ үнэ цэнтэй болж ирдэг. Хүн, малын зан дээр нас, хүйс, өвчлөл, он цаг, цаашлаад генетикийн судалгаа ч хийгдэх бүрэн боломжтой. Олдворуудын хувьд ч мөн адил бүтцийн судалгаа, дүрслэл, бэлгэдэл, зориулалт, хэлбэр, хийц гэх мэт баялаг мэдээллийг авч болно. Анхны эх сурвалж нь тодорхойгүй, гар дамжсан олдворууд тийм ч үнэ цэнтэй биш. Сүүлийн үед тонуулчид археологийн дурсгалыг ухаж сүйтгэх, олдвор хэрэглэгдэхүүнийг дамжуулан зарах явдал нэлээд нэмэгдэж байна. Ингэж ирсэн олдворын мэдээлэл өгөх боломж эрс багасах сөрөг талтай. Өөрөөр хэлбэл, малтлагаар илэрсэн хөрсний судал шинжлэх ухааны чухал ач холбогдол бүхий мэдээллийг хэдэн зуун жилийн турш хадгалж байж болно. Гэтэл түүнийг тонож сүйтгэвэл тэр мэдээллийг хэзээ ч авч чадахааргүй устгаж байгаа юм. Археологийн биет дурсгалыг хамгаалах үүднээс төрийн байгууллагуудын хүрээнд олон

удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж ирсний үр дүнд 2015 онд Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулсан ба 25 дугаар бүлэг бүтнээрээ "Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг" гэсэн нэртэйгээр мөрдөгдөж байна.

**Манай улсад хүрлийн үеийн буган чулуун хөшөө болон хиргисүүр элбэг тааралддаг. Хэлбэр бүтэц, дүрслэлийн хувьд юуг илэрхийлэхийг зорьсон байдаг нь их сонирхолтой санагддаг ...**

-Хиргисүүр, буган хөшөө нь нэг соёл гэдгийг эрдэмтэд нийтээр хүлээн зөвшөөрөөд байна. Хиргисүүр, буган чулууны соёлыг тээгчид нь Монголын төв, баруун бүс нутагт аж төрж байсан эртний нүүдэлчин ард түмэн юм. Үүний зэрэгцээ дөрвөлжин булшны соёлт монгол төрхийн нүүдэлчид Монгол орны төв, зүүн, Байгаль нуурын өмнөд хэсгийн хээр талын бүс нутагт зэрэгцэн оршин тогтнож байжээ.

Монгол нутагт нүсэр зохион байгуулалт бүхий хиргисүүрүүд олноор тархсан бөгөөд тэдгээрийн ойролцоо буган чулуун хөшөө цөөнгүй тааралдах нь бий. Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт Жаргалантын ам хэмээх газарт 30 гаруй буган хөшөө бүхий хамгийн том цогцолбор дурсгал байдаг. Буган хөшөөг баатар дайчин эрсийн дурсгалд зориулж, хүнийг төлөөлүүлэн босгосон гэж үздэг. Хөшөөний дээд буюу толгойн хэсэгт ээмэг, зүүлт, дунд хэсэгт нь бугыг бодитоор болон загварчилсан байдлаар дүрсэлдэг. Мөн бусад амьтныг ч бас харж болно. Доод хэсэгт нь олон янзын хөшөө, гоёмсог бүсийг зэр зэвсэг зүүсэн байдалтайгаар дүрсэлсэн байдаг. Мөн хүний нүүр царайг дүрсэлсэн хөшөө ч цөөнгүй бий. Бүрэн хөшөөний сонгодог төрөл болох бугын загварчилсан дүрслэлтэй хөшөөд нь Хангайн нурууны бүс нутагт төвлөрөх бөгөөд эндээс тархсан болохыг сүүлийн үеийн судалгаа харуулж байна. Мөн Евразийн хээр талын бүс нутагт гурван төрлийн 1500 гаруй буган хөшөө байдаг нь тогтоогдсоноос Монгол Улсын нутагт 1200 гаруй нь илэрч олдсон байна.

**Үлдсэн 200 орчим буган чулуун хөшөө нь Төв Азийн нутаг, өөрөөр хэлбэл манайхтай соёлын хувьд адил төсөөтэй улс орнуудаас олдсон гэж хэлж болох уу?**

-Үлдсэн 200 гаруй буган хөшөө нь Хятадын Шинжаан-Уйгурын бүс нутаг Тэнгэр уул, Буриад, Тува, Уулын Алтай, цаашлаад Казахстан, Урал, Кавказын нуруу, Оросын Оренбург муж, Украин, Румын, Болгарын нутагт байдаг. Манай судлаачид 2018 онд "Монгол ба бүс нутгийн буган чулуун хөшөөний соёл" хэмээх эрдэм шинжилгээний бүрэн каталогийг хоёр дэвтрээр хэвлүүлсэн. Энэ бүтээлээс дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

**Ярилцсанд баярлалаа. Таны эрдэм шинжилгээ, судалгааны ажилд өндөр амжилт хүсье.**

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

## ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

(Түрүүч нь №13-д)

**БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор (Ph.D), хошууч Т.СҮХБААТАР**

Халхын голын дайны дараагаар ЗХУ-Японы тал Төвийг сахих гэрээг 1941 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан бөгөөд уг гэрээний үзэл санааны дагуу Япон улс нь БНМАУ-ын газар нутгийн бүрэн бүтэн, халдашгүй

АНУ-ын тал Монголын тусгаар тогтнолын асуудлыг авч үзэхдээ ЗХУ-ын өөрийн өмнөд хилийнхээ дагуу бат найдвартай буфер улстай болох сонирхолтой байгааг нь ойлгож тэр зарчмаар шийдвэрлэх хүсэлтэй байжээ. Улмаар 1944 онд АНУ-ын дэд ерөнхийлөгч Х.Уоллес Монголд айлчлаад “Монголчууд тусгаар тогтнох бүрэн эрмэлзэлтэй, өөрсдийгөө одоо ч гэсэн тусгаар улс гэж бодож явдаг, энд Зөвлөлтийн нөлөө хүчтэй тогтсон” гэх

дагуу Хятадын тал Гадаад Монголын хүн амаас санал асуулга явуулж, түүний үр дүнгээр Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөр болсон билээ.

Япон улс дайнд ялагдан бууж өгсний дараа буюу 1945 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр хуралдсан БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 76 дугаар хурлаас “Бүх ард түмний саналыг тус улсын бүх нутаг дэвсгэр дээр 1945 оны 10 дугаар сарын 20-ны өдөр нэгэн

дагалдсан 12 хүнтэй баг Улаанбаатар хотын 3, 5, 8 дугаар хороо, Төв аймгийн Лүн сумын 1 дүгээр багт санал хураалтын явцыг ажигласан байна. Санал хураалтын дараа Ли Фа Жан “Үнэн” сонины сурвалжлагч Ц.Дамдинсүрэнтэй ярилцаж, 11 дүгээр сарын 1-ний өдөр “Гадаад Монголын ард түмний санал хураалтын тухай илтгэл”-ийг ерөнхийлөгч Чан Кайшид өргөн барьжээ. 1946 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр ДИУ-ын Засгийн газраас

тусламж, дэмжлэгийг ЗХУ-аас авахыг хичээж байсан тул Сталины байр суурийг үг дуугүй дагахаас өөр сонголт үлдээгүй юм.

Хятадын коммунист намын зүгээс БНМАУ-ын талаар баримтлах бодлогоо дараах байдлаар томъёолж байв. “Монголын ард түмэн үндэстний өөртөө засан тохинох эрхийн дагуу тусгаар тогтнолыг шаардсан бөгөөд бид ч Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх үүрэгтэй.

# ТУСГААР ТОГТНОЛЫН ТӨЛӨӨХ ХАГАС ЗУУН ЖИЛИЙН ТЭМЦЭЛ

дархан байдлыг хүндэтгэх үүрэг авчээ. Энэ үйл явдал нь дэлхийн томоохон гүрний нэг байсан Японы зүгээс Монголыг бие даасан эрх зүйн субъект гэж үзсэн үйл явдал болсон юм. Нөгөө талаар Монголыг хүлээн зөвшөөрөхөөс нааш Төвийг сахих гэрээ хоёр талд үйлчлэхгүй байжээ.

Дэлхийн хоёрдугаар дайн 1939 оны 9 дүгээр сард эхэлсэн тэр цаг үеэс эхлэн монголчууд ЗХУ-ын талд бат зогсон 1936 онд байгуулсан харилцан тусалцах протоколын дагуу үүргээ үнэнчээр биелүүлж ирсэн. БНМАУ-ын удирдагчид Дэлхийн хоёрдугаар дайны үр дүнгээр тусгаар тогтнолоо олж авахыг хичээн фашизм, нацизмын эсрэг тэмцсэн соёлт хүн төрөлхтний талд баттай зогссон юм.

Дэлхийн хоёрдугаар дайны ид үед ч Монголын тусгаар тогтнолын асуудлыг их гүрнүүд болон Хятадын зүгээс шийдвэрлэх гэж оролдож байсан. Америк, Хятадын тэргүүнүүд 1943 оны Каирын бага хурлаар уулзах үеэр АНУ-ын ерөнхийлөгч Ф.Рузвельт дайны дараа Америк-Хятадын цэргийн холбоог байгуулж, Хятад-Зөвлөлтийн хилийн дагуу АНУ-ын цэргийн баазуудыг байгуулах саналыг тавьсан бөгөөд Чан Кайши ихэд олзуурхан хүлээн авч, хариуд нь Монголыг Зөвлөлтийн нөлөөнөөс гаргаж, Хятадад нэгтгэж өгөх, энэ талаар ЗХУ-д шахалт үзүүлэхийг хүссэн байдаг. Гэвч АНУ-ын ерөнхийлөгч уг асуудалд анхааралтай хандаж, асуудлыг судлан үзэхийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан байна. Монголын асуудлаар бодлогогүй алхам хийвэл ЗХУ-ын бодлого хаашаа ч эргэж мэднэ, нөгөө талаар холбоотон улсуудын дунд асар том үл ойлголцол гарч мэдэхээр байсан тул маш нухацтай судлан хандахаар болжээ.

зэргээр Зөвлөлтийн тусгаар тогтносон бүрэн эрхт буфер улс байгуулах сонирхлыг нь баталж өгсөн нь монголчуудын тусгаар тогтнолыг цаашид дэмжихэд түлхэц болж өгсөн байна.

Холбоотон гүрнүүд хувь заяа нь нэгэнт тодорхой болсон Германыг буулгаж авсны дараа Европын хувь заяаны асуудлаар Крымын хойгийн Ялта хотод 1945 оны 2 дугаар сарын 4-11-ний өдрүүдэд бага хурал зохион байгуулсан юм. Уг хурлаар олон чухал асуудал хэлэлцсэний нэг нь Монголын тусгаар тогтнолыг ДИУ-аар хүлээн зөвшөөрүүлэх, Манжуур дахь Зөвлөлтийн нөлөөг хүлээн зөвшөөрүүлэх, мөн АНУ, Англи хоёр Монголын статус квог хүлээн зөвшөөрөх гэсэн асуудлууд байсан бөгөөд АНУ уг асуудлыг хүлээн зөвшөөрч, ДИУ-ын ерөнхийлөгч Чан Кайшигаар зөвшөөрүүлэх асуудлыг өөртөө авчээ. Хурлын үеэр Японы эсрэг дайнд ЗХУ оролцох нөхцөлийн тухай хэлэлцээрийн эхэнд “Гадаад Монголын (БНМАУ) статус квог хэвээр хадгална” гэж заасан нь Монголын тусгаар тогтнолыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэхэд чухал түлхэц болсон юм.

Хятадын тал хэдийгээр хүчтэй эсэргүүцэж байсан ч нөхцөл байдал холбоотон гүрнүүдийн талд мөн Японыг ялахын тулд ЗХУ, АНУ-аас зайлшгүй тусламж дэмжлэг авах шаардлагатай болсон зэргээс үүдэн БНМАУ-ын статус квог хүлээн зөвшөөрсөн юм. Нөхцөл байдалтай нүүр тулан бууж өгсөн Хятадын тал ЗХУ болон АНУ-ын шахалтад орж, 1945 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Зөвлөлт Холбоот Улс, ДИУ-ын хооронд Найрамдал, холбооны тухай гэрээ байгуулан гарын үсэг зурсан. Гэрээг 30 жилийн хугацаатай байгуулсан бөгөөд заалтад нь ДИУ “БНМАУ-ын тусгаар тогтнолыг одоогийн байгаа хилээр нь зөвшөөрнө” хэмээн заажээ. Дээрх заалтын



зэргээр гаргуулах” тогтоолыг батлан, 85 дугаар хурлаас санал хураалтыг явуулах зааврыг гаргасан байна. Санал хураах төв ба салбар комиссууд байгуулагдан бэлтгэл ажлыг сар хүрэхгүй хугацаанд хангаснаар БНМАУ-ын тусгаар тогтнолыг батлах бүх ард түмний санал хураалт 1945 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн өглөөний зургаан цагт эхэлж 18 аймаг, Улаанбаатар хот, МАХЦ, Хязгаарын цэрэг, ЗХУ-д сурч, ажиллаж байсан 487,285 хүн буюу нийт сонгогчдын 98,6 хувь нь оролцож, бүгд тусгаар тогтнолоо баталжээ. Санал хураалтын дүнгийн тухай Төв комиссын тогтоолыг Улсын Бага хурлын Тэргүүлэгчид батлан 11 дүгээр сарын 10-ны өдөр ЗСБНХУ, ДИУ-ын Засгийн газарт илгээжээ.

ДИУ-ын Засгийн газрын төлөөлөгч Ли Фа Жаныг

тэргүүтэй төлөөлөгчид 1946 оны 2 дугаар сарын 8-ны өдөр Чунчинд очиж, санал хураалтын дүнг танилцуулан Засгийн газартай хэлэлцээ явуулсны дүнд 1946 оны 2 дугаар сарын 13-ны өдөр БНМАУ, ДИУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох, элчин төлөөлөгчөө харилцан суулгах тухай нот бичиг солилцжээ. Гэвч Монгол, Хятадын харилцаанд болон Монголын тусгаар тогтнолын асуудалд бас нэгэн тээг гарч ирсэн нь Хятадын дотоод дахь иргэний дайн байлаа. Олон жил үргэлжилсэн Хятадын иргэний дайнд Мао тэргүүтэй коммунистууд ялах нь бараг тодорхой болсон тул Зөвлөлт-Хятадын харилцааны шинэ чиг хандлагад Монголын тусгаар тогтнолын асуудлыг авч үзэх болсон юм.

Мао тэргүүтэй коммунистууд ЗХУ-тай байгуулсан Гоминданы бүхий л гэрээ, хэлэлцээрийг хүчингүйд тооцон хууль бус гэж үзэх болсон байна. Мао Зөвлөлтийн талд ар, өвөр Монгол нэгдэн Хятадын бүрэлдэхүүнд орох нь нээлттэй хэмээн мэдэгдэх болсон юм.

Зөвлөлтийн тал Японыг ялсны дараа “Хятадын Засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн” болохыг сануулаад, “БНМАУ нь өөрийн арми, өөрийн соёлтой, аж ахуй, соёлын бүтээн байгуулалтаа түргэн ахицтай яваа, тэгээд ч тусгаар тогтнол гэдгийн амтыг аль хэдийн амсаад авсан тул өөрийн тусгаар тогтнолоос сайн дураар хэзээ нэгэн цагт татгалзана гэж найдахад хэцүү” гэж анхааруулж байжээ. Гадаад Монголын тусгаар тогтнолыг дэмжсэн Зөвлөлтийн байр суурь хэвээр байгааг эрс хатуу мэдэгдэхийн сацуу энэ асуудлаарх эцсийн шийдээ хэлэх эрх нь Гадаад Монголд өөрт нь байгаа болохыг сануулжээ. Хятадын коммунист нам улс орны бүтээн байгуулалтад нэн шаардлагатай улс төр, эдийн засгийн ихээхэн

Гэхдээ хэрвээ БНМАУ Хятадтай нэгдэж нийлэхийг хүсвэл тэрхүү хүсэлтийг бид талархан хүлээн авах болно. Зөвхөн Монголын ард түмэн л өөрөө энэ асуудлыг шийдэх эрхтэй” гэж үзэж байв.

БНХАУ 1950 оны 2 дугаар сарын 14-ний өдөр Зөвлөлт-Хятадын шинэ гэрээг байгуулахтай хамт БНМАУ-ын тусгаар тогтносон байдлыг хүлээн зөвшөөрч байгаагаа ноотоор нотолсон байна. Үүнд:



Нэгдүгээрт, 1945 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн бүх ард түмний санал асуулгын дүнг хүндэтгэнэ,

Хоёрдугаарт, 1949 оны 10 дугаар сарын 16-ны өдөр БНХАУ-БНМАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосон хоёр хүчин зүйлийн үндсэн дээр БНМАУ-ын тусгаар тогтносон байдал бүрэн дүүрэн хангагдсан болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрч байгааг дурдсан байна.

Ийнхүү Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулах гэсэн 200 гаруй жилийн мөрөөдөл, үүнээс ХХ зууны эхний хагас зуун жилийн турш тэмцсэн уйгагүй хичээл зүтгэлээр монголчууд бид тусгаар тогтнолоо баталгаажуулж чадсан юм.

Хоёр том хүчирхэг хөршийнхөө дунд оршдог Монгол шиг жижиг улс аль нэг хөршдөө бүрэн уусалгүй, улс төрийн ухаалаг чадварлаг бодлого гаргаж, ирээдүйн сайн сайхныхаа төлөө зарим үнэт зүйлс, эх орончдынхоо амь насыг золиослон байж энэхүү тусгаар тогтнолыг бидэнд өвлүүлэн үлдээж чаджээ.

Халхын голын дайн, дэлхийн хоёрдугаар дайнд ЗХУ шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж, дэлхийд хүчирхэг гүрэн болж гараагүй бол, Чөлөөлөх дайнд Монгол Улс ЗХУ-тай мөр зэрэгцэн тулалдаагүй бол, магадгүй хамгийн чухал нь Монгол Улс нь ЗХУ-ын Сибирь, Алс Дорнодын аюулгүй байдлыг найдвартай хамгаалж чадахуйц газар зүйн маш чухал байршилд (буфер улс) оршиж байгаагүй бол Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаажилт наад зах нь нэлээд олон жилээр сунжрах байсан болов уу.

Монгол Улсынхаа тусгаар тогтнолын төлөө амь биеэ үл хайрлан тэмцсэн үе үеийн эх орончдоо мэхийн ёсолж, тэднийгээ цаг ямагт үргэлж санан дурсаж явах учиртай.



БАХАРХАХ АМЖИЛТЫН ЭЗЭД

“УЛСЫН ТЭРГҮҮНИЙ АХМАДЫН ХОРОО”-ГООР ТОДОРЛОО



Монголын ахмадын холбоо 2019 оны ажлаа дүгнэж БХЯ-ны Ахмадын хороо “Улсын тэргүүний ахмадын хороо”-гоор шалгарууллаа. Салбарынхаа нийт ахмадын эрх ашгийг хамгаалах, боломжит хангамж, хөнгөлөлт үйлчилгээг цаг тухайд нь хүргэх, тэдний өмнө тулгамдсан асуудал, санал хүсэлтийг нь яам, холбогдох байгууллагуудад уламжлан

шийдвэрлүүлэх, түүхт 50 жилийн ойдоо зориулсан ном, баримтат киног бүтээх зэргээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгааг нь өндрөөр үнэлэн тус хороо “Улсын тэргүүний ахмадын хороо”-гоор шалгаруулж, хүндэт өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан байна. Та бүхнийхээ цаашдын ажилд арвин их амжилтыг бэлгэдэн өрөөе.

Хилийн чанадаас ...

МАНАЙ ЭНХИЙГ САХИУЛАГЧИД МАНЛАЙЛСААР ...

ИБНАУ-д явагдаж байгаа НАТО-ийн тэргүүлсэн “Шийдвэртэй дэмжлэг” олон улсын ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний XI ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн үндсэн үүргээ амжилттай гүйцэтгэхийн сацуу эх орон, Зэвсэгт хүчнээ сурталчлах зорилгоор олон бүтээлч ажил, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа юм. Түүнчлэн энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй бусад улс орнуудын Зэвсэгт хүчний цэргийн багуудаас зохион байгуулсан уралдаан тэмцээнд амжилттай оролцсоор байна.



“Шийдвэртэй дэмжлэг” олон улсын ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багуудын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг “Мармал баазын аварга шалгаруулах-2020” тэмцээн буюу 25 километрийн маршид гүйж, хэд хэдэн төрөлд нь амжилт үзүүлээ.

Нидерланд улсын Зэвсэгт хүчний цэргийн багаас зохион байгуулсан “Хүчирхэг залуу” тэмцээнд АНУ, ХБНГУ, Хорват, Гүрж, Бельгийн вант улсын цэргийн багуудтай хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс ахмад Б.Банзрагч (150), дэслэгч Г.Гантулга (084), ахлагч А.Биндэрьяа (032), ахлагч А.Батбаяр (350) нарын

баг тамирчид хоёрдугаар байрт шалгарав. Энд тодруулахад, энэхүү тэмцээний тэргүүн байрт Бельгийн вант улс, гуравдугаар байрт АНУ, тусгай байрт ХБНГУ-ын баг тамирчид тус тус шалгарсан юм.

Мөн Румын улсын цэргийн багаас зохион байгуулсан гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд ХБНГУ, Бельги, Гүрж, Нидерланд, Латви, Унгар зэрэг улсын цэргийн алба хаагчидтай өрсөлдсөнөөс дэслэгч Г.Гантулга (084) ахлагчтай баг мөн л хоёрдугаар байрт шалгарсан амжилтыг үзүүлээ.

Хошууч Д.ХАШХҮҮ

МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ

ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛ

1. Техникийн зохицуулалт

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд “Техникийн зохицуулалт гэж бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж, эсхүл тэдгээрийн агуулгыг тусгаж, эрх бүхий байгууллагаас заавал дагаж мөрдөх баримт бичиг” хэмээн тодорхойлжээ.

**Техникийн зохицуулалтын зорилго нь:** Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

Техникийн зохицуулалтыг нийтээр даган мөрдөж ажиллана. Техникийн зохицуулалтын хэрэгжилтийг улсын хэмжээнд Засгийн газар, хэрэгжилтийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын байгууллага хэрэгжүүлнэ.

Техникийн зохицуулалтыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн Засгийн газар батална.

Техникийн зохицуулалт боловсруулах зааврыг Стандартчилал техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална. Техникийн зохицуулалтын төсөл нь техникийн зохицуулалтын зорилго, шаардлагыг хангасан эсэх талаар Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргана.

Монгол Улсаас гадаад худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтын төслийг батлахаас гурваас доошгүй сарын өмнө Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудад мэдээлнэ. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудаас санал болгож байгаа гадаад худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх, эсэх асуудлыг Гадаад худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

**Техникийн зохицуулалтын зарчим:**  
-Зайлшгүй;  
-Тэнцвэртэй байдал;  
-Ил тод;  
-Хариуцлагатай;  
-Хэрэглэхэд дөхөм;  
-Энгийн хялбар;  
-Дүн шинжилгээ тогтмол хийдэг байх.  
**Техникийн зохицуулалт нь:**  
-Хууль ёсны зорилгод үндэслэсэн Засгийн газрын шийдвэр;  
-Захиргааны шинжтэй заалт;  
-Засгийн газрын заавал биелүүлэх шаардлагыг зохицуулах;  
-Улс орны ашиг сонирхлыг өргөн хүрээнд агуулсан байна.

**Хүчин төгөлдөр техникийн зохицуулалт:**  
-Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт MNTR 1:2008 (Засгийн газрын 2008 оны 159 дүгээр тогтоол);  
-Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт MNTR 2:2011 (Засгийн газрын 2011 оны 304 дүгээр тогтоол);  
-Бялууны төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх

техникийн зохицуулалт MNTR 3:2011 (Засгийн газрын 2011 оны 305 дугаар тогтоол);

-Арьс, ширний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт (Засгийн газрын 2013 оны 300 дугаар тогтоол);

-Импортын согтууруулах ундааны техникийн зохицуулалт (Монгол Улсын Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 64 дүгээр тушаал).

Стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллагын тогтолцоо нь Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний харьяа аймаг, нийслэлийн байгууллагаас бүрдэнэ.

Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төрөөс стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, эрхэлсэн асуудлын хүрээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулах ба Засгийн газар томилж, чөлөөлнө.

2. Тохирлын үнэлгээ

Дэлхийн улс орнуудад хүлээн зөвшөөрөх нэг стандарт, нэг тохирлын үнэлгээ нь Дэлхийн худалдааны байгууллагын худалдаан дахь техникийн саад тогтоогч арилгах ач холбогдолтой юм.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд “Тохирлын үнэлгээ” гэж бүтээгдэхүүн, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцоо нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагаа хэмээн тодорхойлжээ.

“Тохирлын баталгаа” гэж бүтээгдэхүүн нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгааг тодорхойлсон баримт бичгийг хэлнэ.

“Тохирлын гэрчилгээ” гэдэг нь бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад нийцсэнийг тодорхойлсон баримт бичиг юм.

Тохирлын үнэлгээний зорилго нь бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад оршино.

Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг заавал хамруулна. Тохирлын үнэлгээнд заавал хамруулах бүтээгдэхүүний жагсаалт, тэдгээрийн тохирлын баталгаатайгаар Монгол Улсын зах зээлд болон хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална. Тохирлын баталгаа нь тохирлын гэрчилгээ болон нийлүүлэгчийн мэдэгдэл хэлбэртэй байна.

Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээг Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн зөвшөөрнө.

Монгол Улсын аюулгүйн тэмдэг

Аюулгүй байдлын үзүүлэлт, шаардлагыг техникийн зохицуулалтаар тогтооно.

Аюулгүй байдлын үзүүлэлт, шаардлагыг хангасан эсэхэд тохирлын үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага сорилт шинжилгээ, хяналт, баталгаажуулалт хийнэ.

Шаардлага хангасан бүтээгдэхүүнд аюулгүйн тэмдэг олгоно.

Аюулгүйн тэмдгийн хэлбэр, хэмжээ, хэрэглэх журмыг Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

Хуульд өөрөөр заагаагүй бол хүлээн зөвшөөрөгдсөн хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, экспортод гаргах, импортоор оруулахад хяналт, тохирлын үнэлгээнд давтан хамааруулахгүй.

Тохирлын гэрчилгээг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага олгоно.

Тохирлын гэрчилгээ нь Монгол Улсад болон Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон улс орнуудад хүчин төгөлдөр байна.

Тохирлын үнэлгээний байгууллагад лаборатори, техникийн хяналт болон баталгаажуулалтын байгууллага хамаарна.

Тохирлын үнэлгээний байгууллага нь Монгол Улсын хуулийн этгээд байх бөгөөд холбогдох хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

“Тохирлын үнэлгээ” гэж бүтээгдэхүүн нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг хэлнэ.

“Баталгаажуулалт” гэж бүтээгдэхүүн нь тодорхой шаардлагыг хангаж байгааг хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага бичгээр нотлох ажиллагаа юм.

3. Тохирлын үнэлгээний итгэмжлэл

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд “Тохирлын үнэлгээний итгэмжлэл гэж эрх бүхий байгууллагаас тохирлын үнэлгээний байгууллага нь тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжлийн чадвартайг тогтоож, хүлээн зөвшөөрөх ажиллагаа” хэмээн тодорхойлсон.

Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зорилго нь худалдаан дахь техникийн саад тогтоогч арилгах, худалдааг хөнгөвчлөх, бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тохирлын үнэлгээний дүнг олон улс, бүс нутаг, гадаад улс болон үндэсний хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тогтолцоо нь итгэмжлэлийн удирдах зөвлөл, итгэмжлэлийн байгууллага, техникийн хороо, маргаан шийдвэрлэх комисс, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага, итгэмжлэлийн

шинжээчээс бүрдэнэ.

Удирдах зөвлөл нь тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тогтолцооны стратеги, бодлогыг тодорхойлох, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий 15 гишүүнтэй, орон тооны бус байна. Удирдах зөвлөл Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно. Итгэмжлэлийн байгууллага нь Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана.

Итгэмжлэлийг итгэмжлэлийн байгууллага эрхлэн гүйцэтгэх бөгөөд итгэмжлэлийн байгууллагын дүрмийг Засгийн газар батална.

Итгэмжлэл нь тохирлын үнэлгээний байгууллагын тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжлийн чадвартайг тогтоох, хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаа юм.

Итгэмжлэлд:

-Бүх төрлийн лаборатори;  
-Техникийн хяналтын байгууллага;  
-Бүтээгдэхүүн, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллага хамрагдана.

Итгэмжлэгдсэн байгууллага:

-Хүн, малын эрүүл мэнд;  
-Хүрээлэн байгаа орчин;  
-Улс орны аюулгүй байдал;  
-Нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээг хийнэ.

Бүтээгдэхүүнд тавих шаардлагыг техникийн зохицуулалт, стандартаар тогтооно.

Тохирлын үнэлгээний байгууллага нь шаардлага хангасан эсэхийг тогтооно. Тохирлын үнэлгээний байгууллагад тавих шаардлагыг олон улсын стандартаар тогтооно.

Бие даасан үндэсний итгэмжлэлийн байгууллага нь мэргэжлийн чадвартайг тогтоож итгэмжлэлийн гэрчилгээ олгоно.

Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний үр дүнг олон улс, бүс нутагт хүлээн зөвшөөрч тохирлын үнэлгээг давтан хийхгүй.


Монгол Улсын итгэмжлэлийн байгууллага нь олон улсын итгэмжлэлийн гэрээнд гарын үсэг зурсан тохиолдолд хэлэлцээрт нэгдсэн гишүүн орнуудын итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагаас олгосон үр дүнг хүлээн зөвшөөрнө. Энэ нь Монгол Улсад гүйцэтгэсэн тохирлын үнэлгээний үр дүнг хэлэлцээрт нэгдсэн орнууд хүлээн зөвшөөрнө. Мөн хэлэлцээрт нэгдсэн орнуудын итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний үр дүнг Монгол Улс хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм.

Ингэснээр худалдаан дахь техникийн саад тогтоогч багасгах, арилгах боломж бүрдэнэ.

Итгэмжлэлийн стандартууд:

-Лабораторийн сорилт шалгалт, тохируулга-MNS ISO/IEC 17025:2018;  
-Ур чадварын сорилтыг хэрэгжүүлэгч-MNS ISO/IEC 17043:2010;  
-Эмнэлэг-MNS ISO 15189:2015;  
-Бүтээгдэхүүн-MNS ISO/IEC 17065:2013;  
-Менежментийн тогтолцоо-MNS ISO/IEC 17021-1:2016 цуврал;  
-Ажилтан-MNS ISO/IEC 17024:2013;  
-Техникийн хяналт-MNS ISO/IEC 17020:2013.

Бэлтгэл хурандаа Ц.ДОРЖХҮҮ



### Дугаарын зочин

Франц улсын иргэн, монгол судлаач Стив Морел бол Монголын өв соёл, язгуур урлагийг биднээс илүүтэй судалж, дэлхий нийтэд сурталчлан түгээн дэлгэрүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа бөгөөд тэрээр хэдийнээ бидний эцнээ танил болжээ. Түүнтэй цухас хөөрөлдсөнөө уншигч танаа болгоё.



#### Та анх ямар зорилгоор Монгол Улсад ирсэн бэ?

-Манай найз надад Монголын язгуур урлагийн нэг цомог бэлэглэсэн юм. Тэрхүү цомог түүний гарт яаж яваад орсныг нь мэдэхгүй, тэр үед би нэг их тоолгүй шүүгээндээ хийчихсэн. Дараа нь нэг удаа сонирхоод сонсоход уртын дуу, морин хуур, хөөмийн аялгуу байсан нь надад содон байсан. Мэл гайхаж, цэл хөхөрнө гэж ярьдаг байх аа. Яг л тийм зүйл болсон шүү. Тэгээд л ямар учраас, яагаад ийм сонирхолтой, сонсголонтой байгааг цаашид судлах зорилгоор эрэл хайгуул хийж эхэлсэн юм. Монголын соёл, язгуур урла руу би ингэж л анх татагдсан даа.

#### Монголын язгуур урлаг, морин хуур, өв соёлыг судалж, түгээн дэлгэрүүлэх болсон шалтгаан юу вэ?

-Цахим орчноос монголчуудыг нүүдлийн аж ахуй, соёл, хөдөөгийн амьдралыг их үзэж, хардаг байсан. Харин энд ирэхэд огт өөр дүр зураглал ажиглагдсан юм. Жишээлбэл, би Монголд ирэхээсээ өмнө хээр тал нутаг, урт үстэй сайхан монгол бүсгүй, монгол эрчүүд нь цээж нүцгэн, булчинлаг гэх мэт олон зүйлийг харахыг хүсдэг байлаа. Угаасаа тийм төсөөлөлтэй байсан гэхэд болно. "Чингис хаан" нисэх онгоцны буудалд газардсаны дараа би хаана буучлав, бууруу газраа ирчихсэн юм болов уу ч гэж бодсон. Нэг үгээр хэлбэл сэтгэл бага зэрэг гонсойсон. Хөтчөөр ирсэн монгол эмэгтэй маань ч намайг зочид буудалд үлдээгээд хаашаа ч юм яваад өгсөн. Харин гудамжинд таарсан нутаг нэгтэн маань надад их тусалж билээ. Би анхны аяллаа Монгол Улсаас эхлүүлэхээр, олон сайхан зүйлсийг төлөвлөөд ирсэн ч бугд л нурсан мэт санагдаж байв. Би юу хийчих вэ гээд өөртөө гомдож бараг л уйлсан. Харин надтай таарсан франц хүн намайг Ховд аймаг руу дагуулж явсан. Ингээд хөдөө очиход миний төсөөлсөн бүх зүйл байсан шүү.

#### Морин хуур хөгжмийг тань шиг гойд сайн сурсан гадаадын иргэн өөр байхгүй

#### мэт санагддаг. Энэ хөгжмийн юунд тэглээ их татагдсан юм бэ?

-С.Бүжидмаа гэдэг бүсгүй анх надад морин хуур тоглохыг заасан. Тэр хүн энэ хөгжмийг судалдаг байсан учраас морин хуур тоглож сурахаас илүүтэй ёс заншил талаас нь олон зүйл зааж сургасан. Би цааш нь морин хуур, уртын дуу, бий биелгээг судалсаар байна. Хотжиж, техникийн хэрээр уламжлалт зүйлс мартагддаг. Харин монголчуудын хувьд энэхүү гайхалтай хөгжмийг одоо хүртэл уянгалуулж, амилуулсаар байгаа нь тун гайхалтай. Морин хуур бол миний дотнын анд, амьдралын минь аврагч гэж хэлэх дуртай.

Монголчууд нүүдэлчин ард түмэн. Тиймээс бичиж үлдээсэн зүйл ховор. Харин ам дамжуулан ёс уламжлалаа үлдээж ирсэн нь олон баримтаар нотлогддог. Жишээ нь үлгэр, домог, тууль гэх мэтээр. Тиймээс настай хүмүүстэй уулзаж янз бүрийн мэдээлэл олж, үлгэр, домог сонсох дуртай. Мөн баруун, зүүн аймгийн хүмүүс адилхан үг хэлж байгаа хэр нь өөр өөр санааг илэрхийлдэг. Энэ бүгдийг нийлүүлж байж дундаас нь гол санааг нь ойлгож авах нь миний хувьд их чухал. Морин хуурын соёл нь дундаршгүй бөгөөд цаашдаа улам их судалж, мэдэж, мэдсэнээ олон хүмүүст зааж

өгөх хүсэлтэй байгаа.

#### "Уугуул төв"-ийг үүсгэн байгуулах санаа хэзээ төрсөн бэ, төвийнхөө талаар товч танилцуулахгүй юу?

-Өмнө нь би морин хуурыг гэрээрээ заадаг байсан. Төдийлөн олон хүнд хүрдэггүй байлаа. Тийм учраас өнгөрсөн жилийн хавар "Уугуул төв"-ийг байгуулсан. Энэхүү сургалтын төвөөрөө дамжуулан морин хуур хэрхэн тоглохыг бий биелгээний хамтаар заадаг. Гэхдээ цахим хэлбэрээр сургалтаа явуулсаар байгаа. Герман, африк хүн ч морин хуур сурч байгаа шүү. Түүх, домог нь ямар агуулгатай, хуурын татлага бүр нь юуг илэрхийлдэг вэ гэдгийг хүмүүст зааж өгмөөр байна. Орчин үед морин хуурын бүтээлүүд нь уламжлалаас өөр хэв шинжтэй болсон мэт санагдсан. Энэ нь тийм ч сайн зүйл биш. Яагаад гэвэл, монгол хэв шинжийг агуулсан язгуур сайхан аялгуу үгүй болох аюултай. Тийм учраас жинхэнэ язгуур монгол аялгууг л морин хуураар эгшиглүүлэхийг сургана гэж боддог. Тэд маань өөрсдөө бие дааж цааш нь судлаасай гэж хүсдэг.

#### Монгол бичгийг сурах нь гадаад хүний хувьд нэн бэрхшээлтэй зүйл. Таны хувьд яаж ийм гаргууд сурсан юм бэ?

-Чой. Лувсанжавын нэрэмжит Хэл иргэншлийн

дээд сургуульд байхдаа монгол бичгийг судалж эхэлсэн. Эхлээд морин хуур, дараа нь уртын дуу, монгол бичиг гэх мэтээр шат дараалан судалсан. Хольж судалдаггүй гэсэн үг л дээ. Энэ нь надад илүү үр дүнтэй санагдсан юм. Монголд зургаан жил болсноос таван жилийг нь монгол бичиг сурахад зарцуулсан. Бүх зурлага нь домог, утга учиртай. Гайхалтай бичгийн соёл юм. Харин кирилл үсгийг хэрэглэж байгаа нь надад харамсалтай санагддаг. Гэхдээ монгол бичгийн хэрэглээ сүүлийн жилүүдэд ихэссэнд баяртай байгаа. Би яваандаа өөрийнхөө гарын үсгийг монгол бичгээр зурах бодолтой байгаа.

#### Монголчуудын хорхог, боодог хийх, толгой хуйхлах нь гаднынханд тийм ч таатай сэтгэгдэл төрүүлдэггүй ч тэд идсэн хойноо амтанд нь ороод үзсэн харснаа бараг л

мэргэжлийн хүн шиг сэтгэлээ шингээж судлахыг хичээдэг.

#### "Тэнгэрээс буусан од" кинонд тоглох саналыг хэрхэн хүлээж авсан бэ?

"Хувьсал" продакшнний жүжигчин, МУГЖ У.Урнаа кинонд тоглох санал тавьсан. Зураг авалт нь хийгдэхээс жилийн өмнө тийм санал ирсэн юм. Албан ёсоор тохироогүй учраас бараг л мартчихсан байсан. Гэтэл зураг авалт эхлэхийн өмнөхөн кино багийнхан надтай холбогдсон тэр үед л кинонд тоглоно гэдэгтэй итгэсэн. Би ихэвчлэн жүжигчний бус зураглаачийн үүргийг гүйцэтгэдэг байсан учраас дүр бүтээх нь тун сонирхолтой санагдсан шүү.

#### Та цаашдаа Монгол Улсад хэдий хэр хугацаанд байх вэ?

-Би энэ сайхан оронд бүх насаараа амьдармаар байна. Энэ насандаа судлаад барахгүй их ажил бий.

# Стив Морел: БИ МОНГОЛ УЛСАД БҮХ НАСААРАА АМЬДАРМААР БАЙНА

#### мартчихдаг ...

-Тийм арга, хэлбэрээр хийж байгаа учраас хоол нь их амттай болдог байх. Бас таван хошуу мал нь идэж байгаа ургамлаасаа хангалттай шим тэжээлээ авдаг учраас мах нь амттай байдаг юм шиг байна лээ. Францад малын дотор махыг бараг хэрэглэдэггүй. Харин монголчууд хоол хүнсэндээ их өргөнөөр хэрэглэдэг. Би нэгэн удаа хөдөөгийн айлд очоод дотор мах идэж үзсэн юм. Надад гүзээний салат хийж өгсөн. Маш амттай байсан болохоор би их идсэн л дээ.

#### Монгол орны байгалийн дурсгалт олон газраар аялсан нь лавтай. Хамгийн их дурсамж үлдээж, гүн сэтгэгдэл төрүүлсэн газрын тухайд ...

-Энэ улс өргөн уудам, цэлгэр тал нутагтай. Соёл нь ч мөн адил арвин. Би 21 аймгийн хагасаас илүүгээр нь аялсан. Аймаг бүр л байгалийн дурсгалт, өвөрмөц тогтоцтой газруудаар дүүрэн. Увс аймгийн Тэс суманд хамгийн удаан байсан. Бараг л хоёр сар амьдарсан байх.

#### Монголд ирэхээсээ өмнө Франц улсад ямар амил эрхэлж, юу хийдэг байсан бэ?

-Би гэрэл зурагчин, кино дизайнераар ажиллаж байсан. Мэргэжилгүй гэж хэлж болно. Яагаад гэвэл би дипломгүй. Гэхдээ маш олон зүйлийг

#### Монгол Улсад та бараг зургаан жил амьдарч байна. Францад байгаа найз нөхөд тань үүнийг хэрхэн хүлээж авсан бэ?

-Өнгөрсөн зургаан жилийн хугацаанд нэг л удаа төрөлх гэртээ очсон. Францад буцаад очиход гэрийнхэн, найз нөхөд маань намайг хараад их өөрчлөгдсөнийг анзаарсан. Маргаангүй үнэн. Монголд ирээд би өөр Стив болсон. Би Монголд амьдарч, зан заншил, соёл урлагийг нь судлах явцдаа өөрийгөө сэтгэн бодох чадвар, амьдрах арга ухааны хувьд түвшин дээшилсэн гэж боддог. Нөгөө талдаа нэг муу зан чанартай болсон. Хүнд итгэдэггүй, өмнөхөөсөө илүү хашир болсон. Учир нь зарим монгол хүн маш хариуцлагагүй, хэлсэндээ хүрдэггүй. Энэ нь ажил хийхэд хүндрэл учруулдаг. Хэдий соёлын ялгаа, улс үндэстний онцлог байж болох ч хотын соёлтой, эрх чөлөөт нийгэмд хариуцлагагүй байж болохгүй. Улс орны хөгжилд ч дөнгө болно гэж боддог.


#### Та гэрлэсэн үү?

-Би 34 настай. Заяаны хань зам дээр гэдэг үг бий. Гэхдээ яг хаана, аль зам дээр байгааг би таахгүй. Уг нь монгол бүсгүйтэй гэрлэнэ гэсэн мөрөөдөл байдаг. Хэт их шунасан болчих вий ч гэж бас бодогддог л юм.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

#### Үндэсний бахархал,

### Өв соёл



#### Чадамгай ухуулагч

Даргын орлогч Чулууны ангийн дэслэгч Гомбосүрэн, ахлах дэслэгч Гармаа нарын удирдсан салбарын ухуулагч, намын гишүүн байлдагч Жигжидсүрэн байлдагч, түрүүч нарын улс төрийн мэдцийг ахиулж, тэднээс дайчны ариун үүргээ чадамгай биелүүлэхэд нь биетэй тусламжийг үзүүлж байна.

Нөхөр Жигжидсүрэн чөлөөт цагийг ашиглаж байлдагч, түрүүч нарт харуул манааны үүрэг, даргын тушаалыг биелүүлэх, сахилга журмын үндсэн шаардлагууд, гадаад дотоодын олон улсын байдал, ялангуяа Японы фашист нар дайнд ялагдсан тухай тодорхой таниулж байна. Нөхөр Жигжидсүрэн таниулга хийхдээ биеэ сайн бэлтгэдэг учир яриа нь тодорхой сонирхолтой болдог.

#### БУЯНДЭЛГЭР

Батлан хамгаалахын төв архивын сан хөмрөгөөс "Улаан од" сонин. 1945.09.12. Дугаар 195 /2269/. Хуудас 778

## Чөлөөлөх дайны ялалт-75 жил

### ЯЛАЛТ

Ямагт үнэнч, эх орондоо өргөсөн тангарагтай Ялгуусан Улаан армийн хүчтэй мэргэн цохилт Яруусан дуурсах цэрэг эрсийн уухайн түрлэг Ялалтын туг өндөрт намирсан түмний баяр Лугших зүрх нь эрх чөлөөний төлөө цохилж Луу мэт сүрийг үзүүлсэн эрэлхэг баатрууд Лусын хаан догширч номхорсон ширүүхэн өдрүүд Лүндэн тушаал, давшаад командтай хэцүүхэн хормууд Авралын одтой гялалзсан дайчин нөхдийн золбоо Аянга шиг ниргэж дайснаа дарсан гавьяа Алаг дэлхийд амар амгалангийн нарыг мандуулсан Алдрын титэм, мөнхөд дуурсагдах эрхэм үйлс Луйврын дайсан хүчин мөхөсдөж хиар цохиулаад Лайгаа наминчилж Улаан армийн өлмийд сөхөрсөн Лимбэний эгшиглэн, үлээвэр хөгжмийн цоглог аялгуутай Ленинград-Москва, Улаан талбайд цэргийн парад алхана Тэсрэх бөмбөг, дарийн утаат галын шугамд Тэсвэр хатуужил, хатан зоригт начин шонхрууд Тэмцэлд омогшсон баатруудын дурсгал гантиг суварга Түүхт далан таван жилийн ой мандтугай ...

Ахмад дайчин Мондойн БЯМБАЖАВ

#### Эрүүл мэндийн зөвлөгөө

Бидний уламжлалт идээ болох аарц нь махнаас ч илүү уураг агуулдаг гэж хоол зүйчид үздэг. 100 грамм аарцанд 23,9 грамм уураг, 17 грамм тос, 2 грамм нүүрс ус, 150 миллграмм кальци агуулдаг байна. Монгол түмэн аарцыг намар орой бэлтгэж, өвлийн турш хадгалан хавар голдуу хэрэглэдэг ба өвөл алдсан эрдэс бодис, дархлаагаа дэмжиж, хаврын ядаргаанаас сэргийлж хүртдэг байна. Аарц нь хүний биеийн хорыг тайлах, тамиржуулах өндөр ач холбогдолтой, уураг, кальциар баялаг тул элдэв өвчнөөс хамгаалах эрүүл мэндийн ундаа ч гэж нэрлэдэг. Найрлагад нь хүний биед үүсэж бий болдоггүй, орлуулшгүй амин хүчлүүд бүхий уураг, эрдэс бодис, олон тооны бичил элемент агуулсан учир заавал хэрэглэх ёстой. Мөн С, А, В1, Е, РР амин дэм агуулсан байдаг тул цусны даралт ихсэх, зүрх судасны өвчтэй хүмүүс, жирэмсэн эхчүүд, хөхүүл, бага насны хүүхэд, спортоор тогтмол хичээллэдэг хүмүүс түлхүү хэрэглэх нь тустай.

**СОЁМБО СОНИН**  
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.  
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч Хурандаа Батжаргалын ОТГОНБАР  
Эхийг "Соёмбо" сонини редакцияд бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

\*Зар, рекламьг хямд нийтэлнэ.  
\*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.  
\*Зохиогчийн үзэл болон сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.  
\*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018  
И-мэйл хаяг: Mil\_newssoyombo@yahoo.com  
Утас: 70001029

# НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН БОЛООД БУСАД ЭНХ ТАЙВНЫ БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙД

## НҮБ-ЫН БЭЛГЭ ТЭМДЭГ НЬ ЧИДУН ЖИМСНИЙ МӨЧИР

Нэгдсэн Үндэстний Байгууллага хэмээх байгууллагын талаар сонсоогүй хүн энэ дэлхий дээр байхгүй биз ээ. 1943 оны 10 дугаар сард ЗХУ-ын Москва хотноо АНУ, Их Британи, ЗХУ-ын гадаад хэргийн сайд нарын уулзалтаар "Хүн төрөлхтний аюулгүй байдлын талаарх дөрвөн улсын тунхаглал"-ыг гаргасан нь уг байгууллага үүсэх гол эрх зүйн үндэс болжээ. Улмаар 1945 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Герман, Японд дайн зарлаад байсан Холбоотны 50 орны төлөөлөгч АНУ-ын Сан-Франциско хотод цугларан Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийг баталснаар түүхийн хуудас нь эхэлсэн гэж үздэг.

НҮБ-ын далбаа, түүний албан ёсны логог Ерөнхий нарийн бичгийн даргын 1946 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн тогтоолоор албан ёсоор баталсан бөгөөд дэлхийн атласыг Хойд туйлын 00 градусаас таван тивийг багтаасан хөндлөн огтлол бүхий байдлаар дүрсэлсэн нь бүх улс, тэдгээрийн ард түмнийг бэлгэджээ. Түүнийг хүрээлсэн чидун жимсний мөчир нь Эртний Грекийн домогт өгүүлдэг хүч чадал, эв найрамдлын илэрхийлэл юм. Тодруулбал, МЭӨ 5 дугаар зууны үеэс грекчүүд үр тарианы элбэг дэлбэгийг бэлгэдэхээс гадна муу ёрын сүнснийг зайлуулж, сайн сайхан бүхнийг дэлгэрүүлдэг шидтэй гэж уг мөчрийг дээдэлдэг байжээ. Мөн Зевс бурхны охин Эйрин бурхныг муу муухай



зүйлээс хамгаалах гэж толгойд нь уг мөчрийг тавьдаг байсан ба Эйрин энх тайвны бурхан ажээ. Дараа нь Ромын эзэнт гүрэн Эйрин бурхнаас чидун жимсний мөчрийн соёлыг уламжлан авч үлдсэн байна. Энэ нь сүүлдээ Ромын эзэнт гүрний хаадын титэм болтлоо дээдлэгдэх болсон юм. Чидун жимсний мөчрийг дээдлэх ёс нь сүүлдээ дундад зууны үед өрнийн соёлын салшгүй нэгэн хэсэг болтлоо түгэн дэлгэрсэн байна.

## ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ХӨШӨӨ



НҮБ-ын төв байр АНУ-ын Нью Йорк хотод байрладаг. Төв байрны гадна талд хошууг нь зангидсан мэт хэлбэртэй гар бууны хөшөө буй. Өдгөө Нью Йорк хотод очсон сая, сая жуулчид энэ хөшөөний дэргэд зургаа татуулах болжээ. Энэхүү энх тайван, амар амгалан дэлхийг бэлгэдсэн хөшөөг анх Шведийн уран барималч Карл Фредрих Ройтершвалд Битлз хамтлагийг үүсгэн байгуулагч Жон Ленноны үрхлийн дараа түүний гэгээн дүрсгалд зориулж 1982 онд урлажээ. Хөшөө нь 1983 оноос Люксембургын вант улсын төв цэцэрлэгт

сүндэрлэж байгаад 1988 онд Нью Йорк хот дахь НҮБ-ын төв байранд иржээ. Мөн олон улсын хүчирхийллийн эсрэг хөтөлбөрийн бэлгэ тэмдэг нь тус хөшөө аж. Уг хөтөлбөр нь залуусын хөгжил, боловсрол, амьдрах ухаан, тэдэнд урам зориг өгөх үндсэн үүрэгтэйгээр дэлхийн 50 гаруй улсад үйл ажиллагаагаа явуулдаг томоохон байгууллага ажээ. Өдгөө тус хөшөөний хуулбар нь Швед, АНУ, Люксембург, БНХАУ, ХБНГУ, Франц, Швейцар, Өмнөд Африк, Мексик, Энэтхэг зэрэг улсад байдаг гэнэ.

## НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САН (UNICEF)



НҮБ-ын дэргэд 15 байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэд ч мөн өөрсдийн гэсэн өнгө төрх бүхий таних тэмдэг, далбаагаараа бусдаасаа ялгардаг. Тухайлбал, НҮБ-ын Хүүхдийн сан

(UNICEF)-гийн логод дэлхийг дүрсэлсэн нь уг сан нь дэлхийн өнцөг булан бүрд хүүхдүүдэд анхаарал халамж тавихыг бэлгэдсэн бөгөөд энэ байгууллагын үйл ажиллагаанд хил, хязгаар гэж үгүй гэдэг утгыг давхар илэрхийлжээ. Мөн дэлхийг хүрээлсэн чидун жимсний мөчир нь энх тайвныг бэлгэдсэн бол дэлхийн дотор байх ээж, хүүхэд хоёр нь НҮБ-ын Хүүхдийн сан нь дэлхийн бүх хүүхдийг тэдний ээж шиг нь хайрлан халамжлахыг илэрхийлдэг аж.

Тус сан нь 1946 онд Дэлхийн хоёрдугаар дайны хөлд нэрвэгдсэн Европын хүүхдүүдэд туслах зорилгоор анх байгуулагджээ. Гэсэн ч жил ирэх тусам үйл ажиллагаа нь өргөжсөөр дэлхий даяар хүүхдүүдийн төлөө төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг маш том байгууллага болжээ.

## НҮБ-ЫН ДЭЛХИЙН ХҮНСНИЙ ХӨТӨЛБӨР (WFP)



Тус байгууллага нь дэлхийн хамгийн том хүмүүнлэгийн байгууллагад тооцогддог бөгөөд дэлхий дахинд хүнсний зохистой хэрэгцээ, хангалтын тэнцвэртэй байдлыг хадгалахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Логоны хувьд НҮБ-ын далбааны цэнхэр өнгөнөөс арай бараан

өнгийг сонгосон байдаг нь дэлхийн хүнсний хамгийн чухал хэрэглээ болсон усыг бэлгэджээ. Энх тайвны бэлгэдэл болсон чидун жимсний хүрэн дотор улаан буудай болон эрдэнэ шиш атгасан гарыг дүрсэлсэн нь дэлхий дээрх тариалангийн хамгийн чухал хоёр ургацыг илэрхийлсэн байна.

Дэлхийн хүнсний хөтөлбөр нь 1963 онд байгуулагдсан бөгөөд өнөөдрийн байдлаар жил бүр 83 улсын 100 гаруй сая хүнд хүнсний тусламж үзүүлдэг аж. Төв байр нь Итали улсын Ром хотноо байрладаг бөгөөд дэлхийн 80 гаруй улсад салбар байгууллагуудаа ажиллуулдаг юм. Дэлхийн хүнсний хөтөлбөр байгууллагын гол санхүүжүүлэгч орон нь АНУ, Европын холбоо, ХБНГУ юм.

## ХҮНИЙ ЭРХИЙН ДЭЭД КОМИСС (OHCHR)

НҮБ-ын Хүний эрхийн дээд комисс нь олон улсын Хүний эрхийн байгууллагаас хараат бус үйл ажиллагаа явуулдаг НҮБ-ын дэргэдэх байгууллага юм. Хүний эрхийн энэхүү байгууллага нь НҮБ-аас 1948 онд баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон олон улсын хууль, дүрэм, журмыг НҮБ-д нэгдсэн орнуудад дагаж, мөрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй. НҮБ дахь бусад байгууллагаас өнгөний хувьд эрс ялгаатай ба хар, цагаан өнгөөр логогоо илэрхийлсэн нь дэлхий дахины хүний эрхийн зөрчлийн эрс ялгааг харуулахыг зорьжээ. Мэдээж НҮБ-ын бэлгэ тэмдэг болсон чидун жимсний мөчрийг дүрсэлсэн бөгөөд дотор талд нь дэлхийг галаар дүрсэлсэн ба хүний эрх, эрх чөлөө бамбар мэт асан дүрэлзэхийг бэлгэджээ.

Тус комисс нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 1993 оны тогтоолоор батлагдаж, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.



## ХАМГИЙН АЛДАРТАЙ ЭНХ ТАЙВНЫ БЭЛГЭ ТЭМДЭГ




зэвсэг, D үсгээр (disarmament) ангижруулах, санааг бэлгэдсэн аж. Харин Америкт энэ тэмдгийг иргэний эрхийн хөдөлгөөнүүд ашиглаж эхэлсэн бөгөөд сүүлдээ цөмийн зэвсгээс ангижруулах гэдэг утгаа алдаж, энх тайван гэх ерөнхий утга илэрхийлэх болжээ.

1960-аад онд Вьетнамын дайн хурцдахад америкчууд уг тэмдгийг дайны эсрэг болон нийгмийн хэв журмыг зөрчсөн амьдралын хэв маягтай элдэв гаж хөгжмийн урсгал, шашны эсрэг хөдөлгөөнд ихэвчлэн ашиглаж эхлэв. Цаашлаад, хуучин Чехословакын Зөвлөлтийн эзлэн түрэмгийллийн эсрэг бэлгэ тэмдэг, Өмнөд Африкт

Олон улсад хүн бүрийн мэддэг энх тайвны бэлгэ тэмдэг нь "The Peace symbol" юм. Их Британи улсын Лондон хотын Трафальгарын талбайд 1958 онд олон мянган хүн цуглан цөмийн зэвсгийн эсрэг дэлхийн энх тайвны төлөө жагссан юм. Тухайн үед АНУ, Их Британи, ЗХУ цөмийн зэвсэгтэй болж, хэд хэдэн аймшигт туршилтуудыг хийсэн байжээ. Энх тайвны төлөө жагсагчид уриа лоозон дээрээ дизайнер Жералд Холтронын үг жагсаалд тусгайлан зориулж бүтээсээр

тэмдгийг ашигласан нь одоогийн бидний мэдэх энх тайвны бэлгэ тэмдэг болсон юм. Тэр цагаас хойш дэлхийн бүхий л цөмийн зэвсгийн эсрэг жагсаал, цуглаанд энэхүү тэмдгийг ашиглах болжээ.

Жералд Холтрон нь тэмдгээ далайчид туг ашиглан хоорондоо харилцахад хэрэглэдэг "семафор цагаан толгойн" тэмдэглэлийг ашиглан хийжээ. N үсгээр (nuclear) цөмийн



арьс өнгөөр ялгаварлах үзлийн эсрэг хөдөлгөөн, хүрээлэн буй орчин, эмэгтэйчүүд болон ижил хүйсийн тэгш эрхийг дэмжих, төрөл бүрийн худалдааны зориулалтаар ч хэрэглэх болсон байна.

## ЦААСАН ШУВУУ

Азийн орнуудад тэр дундаа Япон улсад энх тайвныг цаасан шувуугаар дүрслэх нь олонтоо. Цаасан шувуу нь 1945 онд Хиросима хотод хаясан цөмийн бөмбөгийн дэлбэрэлтэд өртсөн Садако Сасаки охины түүхээс эхтэй юм. "Садако болон мянган цаасан шувуу, номд тэрбээр тэсэхийн аргагүй их өвдөлтийг мэдэрч, өвчин шаналалд тарчилж байхдаа хүн төрөлхтнийг ахиж өөрийнх нь мэдрсэн өвдөлтийг бүү мэдрээсэй гэсэндээ хэдэн мянгаар тоологдох цаасан шувууг хийсэн юм гэж гардаг байна. Садако 1955 онд нас барсан бөгөөд түүний гэгээн дурсгалыг хүндэтгэж, жил бүрийн 8 дугаар сарын 6-ны өдрийг япончууд энх тайвны өдөр болгон тэмдэглэдэг.



## ТАГТАА



Библийн сударт "Дэлхийд усан галав юүлэхэд Ноа эцсийн итгэл найдвараа цагаан тагтаад

илгээн нисгэхэд тагтаа чидун жимсний мөчир зуун буцаж ирдэг. Ингэж л Ноа хүн төрөлхтнийг аврах хуурай газар байгааг мэдсэн юм" гэж тэмдэглэн бичсэн байдаг. Үүнээс улбаалж Христийн шашинтай улсуудад орнуудад тагтааг итгэл найдвар, энх тайвны бэлгэ тэмдэг болгосон түүхтэй.

Энэ нь сүүлдээ газар дундын тэнгисийн болон баруун Африкийн орнуудад тархав. Харин Азийн орнууд ХХ зууны дунд үеэс тагтааг энх тайвны бэлгэ тэмдгээ болгосон юм.